# АГУУЛГА


ӨМНӨХ ҮГ . . . . 2

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 3

НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД . . . . 5

1.1 Төрийн албаны хуулийн хэрэгжилт, шинэчлэлийн зорилт . . . . 5
1.2 Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, хяналт . . . . 11
1.3 Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үнэлгээ . . . . 22

ХОЁР. ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД . . . . 28

2.1 Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, томилгоо . . . . 28
2.2 Төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалга, нөхөн хангалт . . . . 35
2.3 Төрийн албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэлт . . . . 40

ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЁС ЗҮЙН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД . . . . 48

3.1 Төрийн албан хаагчийн үр дүнгийн үнэлгээ, урамшуулал ба хариуцлага . . . . 48
3.2 Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт . . . . 56
3.3 Төрийн албан хаагчийн эрхийн хамгаалалт, гомдол маргаан . . . . 58

ДҮГНЭЛТ, САНАЛ. . . . . 62

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН 2016 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХӨДӨЛГӨӨНИЙ СТАТИСТИК МЭДЭЭ . . . . 67

# ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Төрийн албаны зөвлөл 2016 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Монгол Улсын төрийн албаны хувьд 2016 он онцлог жил байлаа. Улсын Их Хурлын болон орон нутгийн ээлжит сонгуулиуд болов. Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдож төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд багагүй өөрчлөлт гарав. Энэхүү өөрчлөлт нь одоогийн үйлчилж буй хууль эрх зүйн хүрээнд явагдсан болно.

Зөвлөл нь 2016 онд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Байнгын хорооны өгсөн удирдамж, чиглэлийн дагуу төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгон шинэчлэх, төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөн хангах, төрийн албан хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэднээс гаргасан санал гомдлыг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх чиглэлээр хууль тогтоомжийн дагуу ажиллаж ирлээ.

Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэх хүрээнд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтцэд хамаарах төрийн захиргааны төв болон түүний харьяа агентлагууд, нутгийн захиргааны байгууллагын удирдлагыг хуулийн дагуу томилуулах санал, зөвлөмжийг Засгийн газар, аймаг нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж ажиллав. Энэ зөвлөмжийн дагуу яамдын төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн түшмэлийн удирдах албан тушаалтнуудыг заавал нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулан, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулан тухайн албан тушаалд томилох шийдвэрийг Засгийн газар болон нутгийн захиргааны удирдлагад гаргаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав.

Салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэхэд анхаарч, төрийн байгууллагуудаас төрийн үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, шуурхай хүргэх чиглэлээр орон нутагт хамтарсан сургалт, өдөрлөг, уулзалт зохион байгуулж төрийн албан хаагчдад шинэ мэдээ, мэдээлэл өгч, мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх сургалт хөгжил, хамтын ажиллагааны шинэлэг арга барилыг эрэлхийлж ажиллав.

Төрийн албан хаагчдыг сургах үйл явцыг эрчимжүүлэх чиглэлээр Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран баталж төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны албан хаагчдыг үйл ажиллагааны чиглэл, ангилал, зэрэглэл, албан тушаалын түвшингээр нь шатлан сургах, хөгжүүлэх ажиллагааг эхлүүллээ.

Төрийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлтийн явцад төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, томилох, чөлөөлөх асуудлыг хуулийн дагуу шийдэх, тэдний хууль ёсны эрх зөрчигдөхгүй байх нөхцлийг хангаж ажиллах талаар холбогдох байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтанд лавлагаа, зөвлөмж, санамж өгч, зөвлөгөө шаардлага хүргүүлж ажилласны зэрэгцээ төрийн албан хаагчдаас ирүүлсэн 630 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэв.

Гадаад харилцаагаа өргөжүүлэх чиглэлээр тайлант онд ахиц гаргав. Тайландын вант Улсын Төрийн албаны комиссийн гишүүд, төлөөлөгчид манайд айлчиллаа. Айлчлалын хүрээнд хоёр байгууллага хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Манай Зөвлөлийн төлөөлөл БНЛАУ-ын Дотоод хэргийн сайдын урилгаар тус улсад айлчилж, өөрийн туршлагаасаа хуваалцаж, сургалт, хэлэлцүүлэг хамтран зохион байгуулав. Мөн Бүгд Найрамдах Казакстан Улсын нийслэл Астана дахь бүс нутгийн хамтын ажиллагааны төрийн албаны сүлжээ байгууллагын "Төрийн албаны шинэчлэл, хамтын ажиллагаа" сэдэвт 2016 оны ээлжит хуралдаанд Төрийн албаны зөвлөлийн төлөөлөл оролцсон нь хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд ач холбогдолтой болов.

Зөвлөл 2017 оныг "ХАРИУЦЛАГА-ҮР ДҮН"-гийн жил болгох санаачлага гаргав. Төрийн байгууллага, албан хаагч, ажилтнаас төсөв зардал, нэмэлт хөрөнгө шаардахгүйгээр үр дүнд хүрэх нь хариуцлагаа дээшлүүлэх, чанаржуулах явдал юм.

Энэхүү тайланд Төрийн албаны зөвлөлөөс 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлыг хураангуйлан нэгтгэж, төрийн албан хаагчдын 2016 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний нэгдсэн статистик мэдээний хамт танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ... БАЛТАВЫН ЦОГОО

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуульд заасан бүрэн эрх болон Улсын Их Хурлаас баталсан Зөвлөлийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд тухайн жилийн зорилт, Төсвийн хуулиар баталсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө үндэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

2016 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн ээлжит сонгуулиуд болж, Засгийн газар шинээр байгуулагдаж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн онцлог жил байв. Нөгөө талаас төрийн албаны харилцаа, түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгоход тодорхой алхам хийсэн жил болов.

Төрийн албаны зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажилладаг бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байдаг. Тайлант онд Зөвлөл нь 42 удаа хуралдаж, 348 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 269 асуудлаар тогтоол гаргасан байна.

Төрийн албаны шинэтгэлийн зорилтийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүдийн санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга ба нэмэлт өөрчлөлтийн төслийн талаар иргэд, төрийн албан хаагчдаар хэлэлцүүлж, санал авах ажлыг Төрийн албаны зөвлөл зохион байгуулж ажиллалаа.

Хэлэлцүүлгийн үр дүнд мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус төрийн албыг төлөвшүүлэх талаар улс төрийн намууд, иргэд олон нийт нэгдсэн ойлголцол, зөвшилцөлд хүрсэн нь чухал ач холбогдолтой боллоо.

Шинээр байгуулагдсан Засгийн газарт хандаж төрийн албаны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар Төрийн албаны зөвлөл зөвлөмж, санал хүргүүлж хамтран ажиллав. Ингэснээр яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг төрийн захиргааны тэргүүн түшмэлийн удирдах албан тушаалтнуудыг заавал нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулан, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулан тухайн албан тушаалд томилох шийдвэрийг Засгийн газар болон нутгийн захиргааны удирдлага гаргаж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав.

Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд "Төрийн албаны цахим шалгалт"-ын системийг бүрэн нэвтрүүлж ажиллалаа. Системийг нэвтрүүлснээр шалгалт ил тод, хүнээс хамааралгүй, шударга, нээлттэй явагдаж, мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийн мэдээлэл нөөцийн санд автоматаар бүртгэгдэх, нөөцөд буй иргэдийн мэргэжил, боловсрол, туршлага зэрэг үзүүлэлтүүдээр шуурхай хайлт хийх боломж бүрдсэн зэрэг давуу тал бий болсон юм.

Төрийн албаны шалгалтын цахим системийг иргэд, олон нийтэд танилцуулах зорилгоор "Нээлттэй өдөрлөг"-ийг, наймдугаар сард төрийн байгууллагын удирдах ажилтнууд, есдүгээр сард төрийн албанд орох хүсэлтэй иргэд, аравдугаар сард хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд зохион байгуулав. Өдөрлөгийн хүрээнд шалгалт өгөхөөр бэлтгэж буй иргэдэд зөвлөгөө өгч,

цахим шалгалтаар өөрийгөө сорих бололцоо олгов. Туршилтын шалгалтанд хамрагдсан 1560 гаруй иргэдийн 12 хувь нь шаардлагатай дүн үзүүлсэн юм.

Зөвлөл 2016 онд төрийн жинхэнэ албаны 544 ажлын байрны сул орон тоог нөхөх захиалгыг хүлээн авч, төрийн албанд орох иргэний мэргэшлийн шалгалтыг төв, орон нутагт 37 удаа зохион байгууллаа. Энэхүү сонгон шалгаруулалтад 5236 иргэн бүртгүүлж, оролцов. Нэг ажлын байранд 1257 иргэн өрсөлдсөн тохиолдол гарсан нь энэ жилийн онцлог төдийгүй төрийн албанд ороход өндөр эрэмбийн өрсөлдөөн их байгааг илтгэлээ.

Удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулалтаар томилох зарчмыг хэрэгжүүлэхэд Зөвлөл онцгой анхаарч ажиллав. Сонгон шалгаруулж, дүгнэлт гаргахдаа томилох эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулалтын комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулж ажилласан нь шинэлэг бөгөөд удирдах, удирдуулах ёс, зарчмын чиглэлээр чухал ач холбогдолтой ажил боллоо.

Тайлант онд төрийн захиргааны төв болон түүний харьяа байгууллагын 142 удирдах албан тушаалд томилогдох иргэдийг сонгон шалгаруулж, дүгнэлт гаргажээ.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллалаа. 2016 онд 544 сул орон тоог нээлттэй сонгон шалгаруулалтаар, 446 сул орон тоог төрийн албанд анх орох иргэдийн нөөцөөс нөхөн бүрдүүлжээ.

Салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудаас төрийн үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, шуурхай хүргэх чиглэлээр орон нутагт хамтарсан сургалт, өдөрлөг, уулзалт зохион байгуулж төрийн албан хаагчдад шинэ мэдээ, мэдээлэл өгч, мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх сургалт хөгжил, хамтын ажиллагааны шинэлэг арга барилыг эрэлхийлж ажиллав.

Төрийн албан хаагчдыг сургах, үйл явцыг эрчимжүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академитай хамтран баталж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны албан хаагчдыг үйл ажиллагааны чиглэл, ангилал, зэрэглэл, албан тушаалын түвшингээр нь шатлан сургах, хөгжүүлэх ажиллагааг эхлүүллээ.

Төрийн албаны зөвлөл 2016 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд санхүү, хүний нөөцийн байгаа бүхий л боломжийг аль болох үр ашигтай ашиглах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллав.

Төрийн албаны зөвлөл нь тайлант онд улсын төсвөөс 518.243.400 төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2016 оны 09 сард тодотгол хийгдэж 489.189.900 төгрөгийн санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг шилэн дансандаа мэдээлж ажиллав.

Ийнхүү Зөвлөл нь 2016 оны үйл ажиллагааныхаа үр дүнг дараах 3 үндсэн хэсэгт хураангуйлж нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:

1. Төрийн албаны хууль, эрх зүйн шинэтгэлийн бодлогын хэрэгжилт
2. Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилгоо
3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, эрхийн хамгаалалт

# НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Төрийн албаны зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, төрийн албатай холбогдох бусад хууль болон Улсын Их Хурлаас баталсан /2015/ "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2016/ зэрэг бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлал, заалтыг удирдлага болгон ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварчлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих чиглэлээр ажиллав.

## *1.1 Төрийн албаны хуулийн хэрэгжилт, шинэчлэлийн зорилт:*

2016 он бол Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн талаар нийгмийн өргөн хэлэлцүүлэг, шүүмж өрнөсөн жил байлаа.

Төрийн албаны зөвлөлөөс өмнөх жилүүдэд Монгол Улсын Их Хуралд хүргүүлсэн тайландаа Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийж, хууль биелэгдэхгүй, зөрчигдөж байгаа шалтгаан, нөхцөл болон түүнийг засч сайжруулах талаар тодорхой санал, дүгнэлтийг тусгасан нь энэхүү өргөн хэлэлцүүлэгийн эхлэл болсон юм. Тухайлбал, 2014 оны тайландаа: "2014 онд яамдыг салгах, нийлүүлэх, нэршлийг солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх зэргээр Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийг нэг бус /тухайн жилд 3/ удаа хийснээр төрийн албаны тогтвортой, залгамж чанартай байх зарчим алдагдахад хүрч байгааг онцлон дурдаад улмаар энэ байдал нь "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан: Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх тухай дотоод аюулгүй байдлын үндэс сулрахад хүргэж болзошгүй хэмжээнд хүрээд байна" гэсэн зарчмын дүгнэлт хийж төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын анхааралд хүргэсэн.

Тэгвэл, 2015 оны тайландаа: **"Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуулинд иж бүрэн, цогц өөрчлөлт оруулах замаар төрийн албаны харилцааг боловсронгуй болгох, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, тодорхой болгох зайлшгүй шаардлага байна"** гэсэн саналыг дэвшүүлж Улсын Их хуралд хүргүүлсэн билээ.

Төрийн албаны зөвлөлийн энэ дүгнэлтэд Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч болон улс төрийн намууд онцгой анхаарал хандуулж, асуудлын шийдэл, санал, санаачлагуудыг гаргах болсон юм. Үүний нэг тод илрэл нь Ерөнхийлөгчийн санаачлагаар Монгол Ардын Нам болон Ардчилсан Намын удирдлагууд оролцсон нээлттэй уулзалт ярилцлага зохион байгуулж, төрийн албаны хуулийг шинэчлэн өөрчлөх талаар улс төрийн нэгдсэн шийдэлд хүрсэн явдал билээ.

Энэ шийдлийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж "Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-ийг санаачлан 2015 оны 07 дугаар сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын мөн оны намрын чуулганаар төслийг хэлэлцээд

Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг “Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд нарын санаачилсан төсөлтэй хамтатган хэлэлцэх тухай шийдвэр гаргаж Төрийн байгууллалтын байнгын хороонд шилжүүлсэн юм.

Тус шийдвэрийн дагуу Төрийн Байгууллалтын Байнгын Хороо 2015 оны 12 дугаар сард 08 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг нэгтгэн боловсруулж, Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй улс төрийн намуудын төлөөлөл бүхий Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүүгээр ахлуулан байгуулсан, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн даргаар ахлуулан байгуулсан юм.

Иймд Төрийн албаны зөвлөл болон түүний ажлын алба нь хуулийн төслүүдийн холбогдох баримт бичгүүдийг нэгтгэн боловсруулах, тэдгээрийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлж санал авах, гарсан саналуудыг нэгтгэн хуулийн төсөлд тусгах зэрэг техник, зохион байгуулалтын болон мэргэшил арга зүйн зөвлөгөө туслалцаа өгөх чиглэлээр 2016 онд ихээхэн хүчин чармайлт гарган ажилласан болно. Тухайлбал:

- Бүх аймаг, нийслэл, яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлөөр дамжуулан хуулийн төслийн талаар иргэд, төрийн албан хаагчдын саналыг авах ажлыг зохион байгуулав.
- Хэлэлцүүлэгт хорин мянга шахам төрийн албан хаагчид оролцсон бөгөөд хуулийн төслүүдтэй холбоотой 300 шахам санал гарсныг багцалж нэгтгэх ажлыг Зөвлөлийн ажлын алба гүйцэтгэв. Мөн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан 62 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын үндэслэлийг боловсруулсан болно.
- Эдгээр саналыг хуулийн төсөлд оруулах эсэх асуудлаар ажлын дэд хэсэг 20 гаруй удаа хуралдаж, санал дүгнэлтээ нэгтгэн Төрийн байгууллалтын байнгын хорооны ажлын хэсэгт шилжүүлсэн.

Ийнхүү Зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх талаар Улсын Их Хурал болон хууль санаачлагчдаас гаргасан санаачлагыг бүх талаар дэмжиж ажилласан болно.

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэгдсэн хэлэлцүүлгийг Төрийн байгууллалтын байнгын хорооны 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн байна. Энэ хуралдаанаар хуулийн төслүүдтэй холбогдон гарсан зарчмын зөрүүтэй 43 санал, найруулгын 55 санал, хуулийн төслийн дагалдсан 62 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхэд Зөвлөлийн ажлын алба мэргэшил арга зүйн болон техникийн туслалцаа үзүүлж ажиллав.

Тус Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдож гарсан зарчмын зөрүүтэй 37 саналын томъёоллыг хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

- **32 санал-**Дэмжигдсэн /найруулгын өөрчлөлт орж дэмжигдсэн-4/

- **2 санал-**Дэмжигдээгүй
- **2 санал-**Нээлттэй орхисон /дахин хэлэлцэх/
- **1 санал-**Хууль санаачлагч татаж авсан.

Найруулгын шинжтэй 55 саналыг хэлэлцэн үндсэнд нь дэмжсэн.

Дагалдах 62 хуулийн төслөөс 30 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг хууль санаачлагчийн зүгээс татаж авахаар тогтсон бөгөөд үлдсэн 32 төслийг дэмжиж нэгдсэн хуралдаанд оруулахаар шийдвэрлэсэн болно.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хуулийн төсөлд тусгагдсан төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбогдох хэсгийг хэлэлцэж, төрийн албан хаагчдад олгох тусламж, нөхөх төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн талаар болон орон сууцаар хангах асуудалтай холбогдуулан гишүүдээс гарсан зарчмын шинжтэй 5 саналыг дэмжиж хуулийн төсөлд тусгуулах тухай шийдвэр гаргасан болно.

Мөн Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгагдсан хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдох хэсгийг хэлэлцэж зарчмын зөрүүтэй 7 саналын томъёоллуудыг гаргасан болно.

Зөвлөл дээрх Байнгын хороодын хурлаас гарсан саналын талаар тайлбар, үндэслэлийг бэлтгэж Төрийн байгуулалтын байнгын хороо болон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

Ийнхүү Зөвлөл төрийн албаны эрх зүйн шинэтгэлийг дэмжиж, хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гарган ажилласан боловч уг хуулийн төслийн нэгдсэн хэлэлцүүлгийг хийж амжилгүйгээр Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон юм.

Шинээр байгуулагдсан Их Хурал энэхүү хуулийн төслийг санаачлагчид нь буцаасан учир Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин санаачлан 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа юм. Энэхүү хуулийн төсөл нь нийт 6 зүйлтэй бөгөөд холбогдох 8 хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дагалдуулсан байна.

**Төрийн байгууллагын бүтцийн өөрчлөлт, хуулийн хэрэгжилт.** Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн байдалд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажиллах нь Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны нэг хэсэг билээ. 2016 он бол Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад нэлээдгүй өөрчлөлт гарсан жил байлаа.

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд төрийн захиргааны байгууллагын бүтэц, тогтолцоо хэрхэн өөрчлөгдөж ирсэн байдлыг Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрт үндэслэн авч үзэхэд төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт нь тогтвортой биш, сонгуулиас сонгуулийн хооронд 4 жил тутамд өөрчлөгдөж байсан бөгөөд ялангуяа 2012 оноос яам, агентлагийн бүтэц зохион байгуулалтад бараг жил тутам өөрчлөлт хийгдэж ирсэн дүр зураг харагдаж байна.

**Яам, агентлагийн тоо** /1992-2016 он/

| № | Он / Байгууллага | 1992 | 1996 | 2000 | 2004 | 2008 | 2012 | 2013 | 2014-10 сар | 2014-12 сар | 2015-12 сар | 2016-7 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Яам | 16 | 9 | 11 | 13 | 11 | 16 | 16 | 13 | 15 | 15 | 13 |
| 2 | Засгийн газрын тохируулагч агентлаг | - | 22 | 17 | 14 | 12 | 11 | 11 | 11 | 10 | 9 | 10 |
| 3 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг | - | 37 | 31 | 23 | 31 | 17 | 19 | 19 | 19 | 18 | 17 |
| **Нийт агентлагийн тоо** | | **-** | **59** | **48** | **37** | **43** | **28** | **30** | **30** | **29** | **27** | **27** |
| **НИЙТ ДҮН** | | | **68** | **59** | **50** | **54** | **44** | **46** | **46** | **44** | **42** | **40** |

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн жилүүдэд яам, агентлагийн тооны өөрчлөлт харьцангуй тогтвортой, хэлбэлзэл багатай, жилээс жилд буурах хандлагтай мэт байна.

Хэдийн тийм боловч яамдыг салгах, нийлүүлэх, нэршлийг солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх зэрэг хөдөлгөөнийг 2012 оноос хойш 5 удаа, зарим жилд 2-3 удаа хийж ирсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд бүтцийн өөрчлөлтийг богино хугацаанд ийнхүү олон удаа хийсний улмаас төрийн албан хаагчдын хөдөлгөөн ихсэж, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг алдагдуулахад хүргэж байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатайг Төрийн албаны зөвлөл жил бүрийн тайландаа дурдаж, сануулсаар ирсэн.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийг ингэж өөрчлөхдөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттойгоо уялдуулж орон тоо бууруулах, төсвийн ачааллыг багасгах, хэмнэх зарчмыг баримталж байгаа мэт боловч шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, тооцоо, чиг үүргийн шинжилгээнд үндэслэдэггүй, төрийн албаны төв болон холбогдох бусад байгууллагын санал авдаггүй явж ирсэн байдал давтагдсаар байна.

2016 оны хувьд онцлог жил билээ. Улсын Их Хурлын ээлжит сонгууль болж, засгийн эрх иргэдийн сонголтоор хуулийн дагуу улс төрийн нэг хүчнээс нөгөөд шилжсэн явдал юм. Сонгуулийн үр дүнд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ордог нь нийтлэг жишиг байдаг. Энэ жишгийн дагуу шинээр бүрдсэн Улсын Их Хурал нь Засгийн газрын бүтцийн тухай хуулийг шинэчлэн баталсан юм.

Ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан шинэ Засгийн газрын бүтцийг өмнөх Засгийн газрын бүтэцтэй харьцуулан доорх хүснэгтээр харуулав.

| | **Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай 2014.12.04-ний өдрийн хууль** | | **Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай 2016.07.21-ний өдрийн хууль** |
|---|---|---|---|
| **№** | **2014.12.15 ЗГ-ын 382 дугаар тогтоол** | **№** | **2016.07.27 3-р тогтоол** |
| **1** | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам | **1** | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| **2** | Барилга, хот байгуулалтын яам | **2** | Барилга, хот байгуулалтын яам |
| **3** | Батлан хамгаалах яам | **3** | Батлан хамгаалах яам |
| **4** | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | **4** | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| **5** | Гадаад хэргийн яам | **5** | Гадаад харилцааны яам |
| **6** | Сангийн яам | **6** | Сангийн яам |
| **7** | Уул уурхайн яам | **7** | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| **8** | Зам, тээврийн яам | **8** | Зам, тээвэр, хөгжлийн яам |
| **9** | Аж үйлдвэрийн яам | | |
| **10** | Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам | **9** | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| **11** | Хөдөлмөрийн яам | | |
| **12** | Хүнс, хөдөө аж ахуйн яам | **10** | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| **13** | Хууль зүйн яам | **11** | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| **14** | Эрүүл мэнд, спортын яам | **12** | Эрүүл мэндийн яам |
| **15** | Эрчим хүчний яам | **13** | Эрчим хүчний яам |

Эндээс үзэхэд яамдын тоог хоёроор цөөлж, ерөнхий чиг үүргийн яамны тоог нэгээр нэмэгдүүлж 6 болгож, чиглэлийн 7 яамтай байхаар Засгийн газрын бүтцийг баталсан байна. Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны чиг үүргийг нэгтгэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон өөрчилсөн төдийгүй тус яамыг ерөнхий чиг үүргийн яамны бүтцэд нэмж оруулсан нь эрх баригч намын үзэл баримтлал, бодлогын илрэл гэж үзэж байна. Аж үйлдвэрийн яамыг татан буулгаж, чиг үүргийг нь өөр яамд болон агентлагт хуваарилах байдлаар өөрчлөн байгуулжээ. Тухайлбал, хүнд үйлдвэрийн асуудлыг Уул, уурхайн яаманд, хөнгөн үйлдвэрийн асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хариуцуулснаас гадна концессийн асуудлыг шинээр байгуулсан Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газарт хамааруулсан байна. Мөн спортын асуудлыг Эрүүл мэнд, спортын яамнаас Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд шилжүүлж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болгон өөрчлөн байгуулжээ.

Ийнхүү өмнөх Засгийн газрын 15 яамнаас 7 яамны чиг үүргийг нэгтгэх, өөрчлөх замаар 5 яам болгон өөрчлөн байгуулсан бол үлдсэн 8 яамны чиг үүргийг үндсэнд нь хэвээр хадгалж залгамж чанарыг хадгалсан байна.

Яамдын аппаратын орон тооны дээд хязгаарыг Засгийн газраас тогтоохдоо өмнөхөөс 7 орчим хувиар бууруулан баталжээ. Эндээс үзэхэд шинэ Улсын Их Хурал Засгийн газрын бүтцийн тухай хуулийг батлахдаа яамдын тоог цөөлөх, орон тоог багасгах, яамдын бүтэц, чиг үүрэг, бодлогын залгамж шинжийг хадгалах чиглэлийг баримтлахыг эрмэлзсэн нь

харагдана. Үүнийг 2012 онд 11 яамыг 15 яам болгох замаар Засгийн газрын бүтцийг өөрчлөн баталсантай харьцуулахад огцом эрс өөрчлөлт биш, харьцангуй тогтвортой байдлыг хадгалах гэсэн хандлага гэж үзэж байна. Энэ хандлага агентлагуудын түвшинд ч мөн адил харагдаж байгаа юм.

**Засгийн газрын тохируулагч агентлагууд** /Харьцуулалт 2015, 2016 он/

| № | Засгийн газрын 2015 оны 501 дугаар тогтоол | № | Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоол |
|---|---|---|---|
| 1 | Тагнуулын ерөнхий газар | 1 | Тагнуулын ерөнхий газар |
| 2 | Зэвсэгт хүчний жанжин штаб | 2 | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| 3 | Цагдаагийн ерөнхий газар | 3 | Цагдаагийн ерөнхий газар |
| 4 | Хил хамгаалах ерөнхий газар | 4 | Хил хамгаалах ерөнхий газар |
| 5 | Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар | 5 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар |
| 6 | Онцгой байдлын ерөнхий газар | 6 | Онцгой байдлын ерөнхий газар |
| 7 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 7 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| 8 | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар | 8 | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар |
| 9 | Стандартчилал, хэмжил зүйн газар | 9 | Стандарт, хэмжил зүйн газар |
| | | 10 | Үндэсний хөгжлийн газар |

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлагийн тоо, нэршил үндсэндээ тогтвортой байна. Үндэсний хөгжлийн газрыг шинээр байгуулсан нь 2016 онд баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой байна. харин хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулж, салбар хоорондын бодлогын уялдаа холбоо, удирдлага зохицуулалтыг хангах төрийн бодлогын чиг үүргийг хэрэгжүүлэгч нь тохируулагч агентлаг байх уу, бодлогын бие даасан яам байх уу гэдэг нь цаг хугацааны шалгуураар тодорхойлогдох асуудал юм.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын тоо хэмжээ, бүтэц, нэршилд харин нэлээдгүй өөрчлөлт орсон нь доорх харьцуулсан хүснэгтээс харагдаж байна.

**Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн харьцуулалт** /2015-2016/

| № | Засгийн газрын 2015 оны 501 дугаар тогтоол | № | Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоол |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө оруулалтын газар | 1 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| 2 | Худалдан авах ажиллагааны газар | 2 | Цаг уур, орчны шинжилгээний газар |
| 3 | Оюуны өмчийн газар | 3 | Гаалийн ерөнхий газар |
| 4 | Цаг уур, орчны шинжилгээний газар | 4 | Татварын ерөнхий газар |
| 5 | Гааль, татварын ерөнхий газар | 5 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар |
| 6 | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар газар | 6 | Архивын ерөнхий газар |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Архивын ерөнхий газар | 7 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| 8 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 8 | Гадаадын иргэн харъяатын газар |
| 9 | Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар | 9 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар |
| 10 | Тахарын ерөнхий газар | 10 | Хөдөлмөр, халамжийн ерөнхий газар |
| 11 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 11 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| 12 | Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар | 12 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |
| 13 | Хүүхдийн төлөө үндэсний газар | 13 | Иргэний нисэхийн ерөнхий газар |
| 14 | Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар | 14 | Ашигт малтмал, газрын тосны газар |
| 15 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 15 | Мал эмнэлэг, үржлийн газар |
| 16 | Ашигт малтмалын газар | 16 | Биеийн тамир, спортын газар |
| 17 | Газрын тосны газар | 17 | Соёл, урлагийн газар |
| 18 | Мал эмнэлэг, үржлийн газар | | |

Өмнөх Засгийн газрын 18 хэрэгжүүлэгч агентлагийг 17 агентлаг болгон тоог нэгээр бууруулсан. Ингэхдээ өмнө байсан Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Оюуны өмчийн газар, Тахарын ерөнхий газар, Газрын тосны газар гэсэн 5 агентлагийг татан буулгаж, чиг үүргийг нь өөр агентлагт шилжүүлэн нэгтгэсэн бол шинээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Биеийн тамир, спортын газар, Соёл, урлагийн газар гэсэн 3 агентлагийг шинээр байгуулсан байна.

## *1.2 Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, хяналт:*

Төрийн албаны зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажилладаг бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т зааснаар Зөвлөл нь дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд тэдгээрийн 2 нь орон тооны, 4 нь орон тооны бус гишүүдээс бүрддэг.

2016 он бол Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнд нэлээдгүй тодорхой өөрчлөлт орсон жил байснаараа онцлог юм.

Тайлант онд Зөвлөлийн орон тооны 2 гишүүн, орон тооны бус нэг гишүүн буюу Зөвлөлийн нийт 7 гишүүний 3 нь өөрчлөгдсөн байна. “Зөвлөлийн орон тооны гишүүнээр нөхөн томилогдсон хүн нь орон гарсан өмнөх гишүүнийхээ бүрэн эрхийн үлдсэн хугацаанд уг албыг хашина” гэсэн Төрийн албаны тухай хуулийн 34.12-т заасан үндэслэлээр 2013 онд Зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогдсон Д.Даваа-Очир, Т.Хадхүү нарыг чөлөөлөх шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргасан юм.

Иймээс орон гарсан Зөвлөлийн орон тооны 2 гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлсэн Б.Баатарзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр дэвшүүлсэн С.Цэдэндамба нарын тухай Төрийн байгууллалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2016 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн



нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, "Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай" 25 дугаар тогтоол гарснаар Зөвлөлийн бүрэлдэхүүн бүрдсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдсон Ц.Цолмон Зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр орсон юм.

Төрийн албаны зөвлөл шинэ бүрэлдэхүүнтэйгээр анхны хуралдаанаа 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдөр хийснээс хойш 4 сар гаруй хугацаанд 20 удаа хуралдаж, 255 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн нь тайлант онд Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн нийт асуудлын 70 гаруй хувийг эзэлж байна.

**Төрийн албаны зөвлөлийн хуралдаан.** Төрийн албаны тухай хуулийн 34.1, 34.2, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.1, 4.2, 4.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн хуралдаан 2016 онд нийт 42 удаа хуралдаж, 348 асуудлыг хэлэлцэн **269** асуудлаар тогтоол шийдвэр гаргажээ. Хурлын тэмдэглэлийг бүрэн хөтөлж, албажуулан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлын тоймыг бэлтгэн, Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудаст байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлж, шаардлагатай мэдээллийг өдөр тутмын зарим мэдээллийн хэрэгсэл, сонин хэвлэлээр түгээн ажиллав.

Төрийн албаны зөвлөлийн 2016 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг сэдэв, агуулга, тэдгээрийн давтамжаар нэгтгэн доорх хүснэгтээр харуулав.

| Он | Хуралдааны тоо | Хэлэлцсэн асуудлын тоо | Гаргасан шийдвэрийн тоо |
|---|---|---|---|
| 2015 | 38 | 264 | 233 |
| 2016 | 42 | 348 | 269 |

Үүнд: Хуралдааны тоо, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийнхээ тоогоор өмнөх бүх жилүүдийнхээс давсан нь тайлант онд Зөвлөл ихээхэн ачаалалтай ажилласны илрэл гэж үзэж болно. Хэлэлцсэн асуудлын тоо өмнө оныхоос 24.1 хувиар илүү байгаа нь үүнийг нотолно.

Хуралдаанаар хэлэлцсэн нийт асуудлын 69.2 хувь нь удирдах албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалтын дүн мэдээ, ажлын байрны сул орон тоог зарлах, сонгон шалгаруулалтын дүн, тайланг хэлэлцэх асуудлууд эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинээр батлагдаж, яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой.




Дээрх графикаас харахад Төрийн албаны зөвлөлийн 2016 оны хуралдаанаар хэлэлцсэн 348 асуудлаас удирдах ажилтанд дүгнэлт гарган нэр дэвшүүлэх асуудал 31 хувь, Сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй зарлах асуудал 20 хувь, Нээлттэй сонгон шалгаруулалтын дүн мэдээг хэлэлцэх асуудал 18 хувь, Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал 13 хувийг тус тус эзэлж байна.

***2016 оныг 2015 онтой харьцуулбал:***

| № | Хэлэлцсэн асуудал | 2015 он | 2016 он |
|---|---|---|---|
| 1 | Удирдах ажилтанд дүгнэлт гарган нэр дэвшүүлэх | 75 | 107 |
| 2 | Удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлах | 34 | 71 |
| 3 | Удирдах ажилтныг сонгон шалгаруулсан тайлан, дүн | 24 | 63 |
| 4 | Анх орох иргэдийн сонгон шалгаруулалтын дүн, нөөцөд бүртгэн нэр дэвшүүлэх | 23 | 18 |
| 5 | Нөөцөөс нэр дэвшүүлэх, хасах талаар | 13 | 6 |
| 6 | Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний асуудлаар | 49 | 46 |
| 7 | Төрийн албаны зөвлөлийн дүрэм журмыг шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах талаар | 2 | 6 |
| 8 | Маргаан хянан шийдвэрлэсэн | 10 | 3 |
| 9 | Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох талаар | 8 | 5 |
| 10 | “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдэг олгох асуудлаар | 7 | 6 |
| 11 | Бусад асуудлаар | 10 | 17 |
| **Нийт** | | **255** | **348** |

2016 оны хуралдааны тоймыг өнгөрсөн оныхтой харьцуулбал удирдах албан тушаалд томилуулахаар дүгнэлт гаргах асуудал 28 хувиар, Сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй зарлах асуудал 52 хувиар, Нээлттэй сонгон шалгаруулалтын дүн мэдээг хэлэлцэх асуудал 60 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарч байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд Засгийн газар шинээр байгуулагдсан, яам, агентлагийн бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдсанаар удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах захиалга ихсэхийн зэрэгцээ, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар өөрчлөгдөж, Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг шинээр томилсонтой холбоотойгоор дээрх үзүүлэлтүүд өсчээ.

Хуралдаанаар хэлэцүүлсэн асуудал бүрээр тодорхой шийдвэр гардаг бөгөөд тэрхүү шийдвэрийн үндсэн хэлбэр нь тогтоол юм. Мөн хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргахаас гадна, хурлын тэмдэглэлд асуудлыг дэмжсэн эсвэл дэмжээгүй буюу буцаасан гэсэн хэлбэрээр шийдвэр гаргадаг. Тэгвэл өнгөрсөн онд хуралдаанаар хэлэлцсэн 348 асуудлын 77,3 хувь буюу 269 асуудлаар хуралдааны тогтоол гаргасан байна. Тогтоолын агуулга, төрөл ангилал, тоог доорх хүснэгтээс тодорхой харж болно.

| № | ТОГТООЛЫН АГУУЛГА | ТОО |
|---|---|---|
| 1 | Удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх | 104 |
| 2 | Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх | 25 |
| 3 | Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох | 20 |
| 4 | Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх, нэр дэвшүүлэх | 64 |
| 5 | Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах | 29 |
| 6 | Удирдах албан тушаалтныг төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэх | 3 |
| 7 | Шагнах тухай | 8 |
| 8 | Дүгнэлт гаргаж, санал хүргүүлсэн | 2 |
| 9 | Маргаан хянан шийдвэрлэсэн дүгнэлтийн тухай | 3 |
| 10 | Тогтоол, журамд өөрчлөлт оруулах | 7 |
| 11 | Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх тухай | 2 |
| 12 | Зөвлөмж хүргүүлэх тухай | 2 |
| | НИЙТ БАТАЛСАН ТОГТООЛ | **269** |

Зөвлөлийн цахим хуудсыг "Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас ажиллуулах журам"-ын дагуу ажиллуулж байгаа бөгөөд тус цахим хуудаст өдөрт дунджаар 1000-1400 гаруй хүн хандаж Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээ, мэдээлэл, хуралдааны хэлэлцэх асуудал, шийдвэрийн тойм, хууль, журам, танин мэдэхүйн мэдээллээс гадна Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар мэдээ, түүнтэй холбоотой лавлагаа мэдээлэл, сонгон шалгаруулалтад орохоор бүртгүүлж буй хүмүүсийн мэдээлэл болон тэдгээрийн шалгалтын дүн, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн мэдээлэл зэрэг олон төрлийн мэдээллийг авч байна.

Өдөр тутмын сонин, телевиз, сайтын сэтгүүлчид тус цахим хуудас дахь мэдээллийг эх сурвалжаа болгон ашиглахын зэрэгцээ байгууллагын дарга, гишүүд, ахлах референтүүдтэй

уулзан ярилцлага, мэдээ, тодруулга бэлтгэн олон нийтэд хүргэж, зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулав.

Зөвлөлийн үйл ажиллагаа болон хуралдааны үйл явц, байгууллагын дотоод ажлын тухай мэдээ, мэдээллийг нийтэд түгээхдээ төрийн нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Төрийн нууцыг хамгаалах журам"-ыг мөрдлөг болгон ажиллаж ирэв.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны нэг чиглэл нь төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байлгах явдал билээ. Энэ талаар Авлигатай тэмцэх газартай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тодорхой ажил зохион байгуулж, төлөвлөгөө гарган ажиллав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан журам, мэдүүлэг, мэдэгдлийн маягт, цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажлын тайланг ХАСХОМ1, ХАСХОМ2 маягтаар гарган нийт 11 албан хаагчийн мэдээг 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Мэдээ хүргүүлэх тухай" 167 тоот албан бичгээр хүргүүлж, мөн "Хамтран ажиллах албан тушаалтны тухай" Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 522 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газрын дэд дарга Ц.Нямдоржид Нэгдсэн Үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын II, Y дугаар бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайланг 2016 оны 8 дугаар сард багтааж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэх ажлын хүрээнд "Зөвлөх үйлчилгээний баг"-ийн зааварчилгаа чиглэл өгөх уулзалтанд Ажлын албаны дарга Д.Баатарсайханыг оролцуулан өөрийн үнэлгээний тайланг хүргүүлэн ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн 2016 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 14 багц, 62 төрлийн ажил, арга хэмжээгээр төлөвлөн Зөвлөлийн даргаар батлуулан, 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 115 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөний биелэлтийг бүрэн гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн тайлагнав.

**Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ.** Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө нь чиг үүрэгтээ тохирсон зөв бүтэцтэй байхаас хамаарна. Төрийн байгууллагын бүтцийн өөрчлөлтийг хийхдээ нарийвчилсан судалгаанд суурилж, бодитой хандах учиртай.

Төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийдэг нэгдсэн арга зүй, аргачлал, шалгуур үзүүлэлт боловсрогдоогүй, тийм цогц шинжилгээ хийгдэж байгаагүй нь төрийн захиргааны оновчтой, тогтвортой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв бүтэц, тогтолцоо бүрдэж чадахгүй байгаагийн нэг шалтгаан болж байна.

Энэ бүхэн нь тухайн байгууллага /яам, агентлаг/, салбар, орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, үр ашиггүй зардал гарахын нэг үндэс болох талтай. Иймээс:

- Монгол улсад хэдэн яам, хэдэн агентлаг, хэдэн төрийн байгууллага байх нь зохистойг, тэнд хичнээн төрийн албан хаагч ажиллахыг ул суурьтай шинжлэн судлаж, тогтоох;
- Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээний нэгдсэн аргачлалтай болох;
- Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын бүтцийг шинэчлэн боловсруулахдаа /ялангуяа Засгийн газрын бүтэц, яам, агентлаг байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулахдаа/ Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11-д заасны дагуу Төрийн албаны төв байгууллагын саналыг харгалздаг байхын зэрэгцээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, чиг үүргийн шинжилгээ хийдэг байгууллага /Шинжлэх ухааны академи, Удирдлагын академи зэрэг/-удтай хамтарч ажилладаг байхыг Төрийн албаны зөвлөл санал болгож байна.

**Хүний нөөцийн талаар хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр.** Төрийн албаны зөвлөл нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн боловсон хүчний бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

Энэ чиг үүргийнхээ дагуу Зөвлөл нь засгийн газар шинээр байгуулагдах бүрт төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, лавлагаа хүргүүлдэг юм.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг тэгш хэрэгжүүлэх чиглэлээр томилох эрх бүхий албан тушаалтнуудад албан бичиг, зөвлөмж, лавлагаагаар арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, захиалга, зарим яамдын Төрийн нарийн бичгийн даргын ажлын байранд тавигдсан шаардлага, томилготой холбоотойгоор Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газарт болон Засгийн газрын гишүүд, сайд нарт 7 удаа / ТАЗ-ийн 2016 оны 822, 159, 459, 823, 824 , 856, 1125/ санал, зөвлөмж хүргүүлж ажиллав.

Шинээр байгуулагдсан Улсын Их Хурлаас Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Засгийн газарт болон яамдын Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт хүргүүлсэн төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ баримталж ажиллавал зохих “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар” арга зүйн зөвлөмжийг Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 849 тоот албан бичгийг хүргүүлсэн байна.

Энэхүү зөвлөмжөөр нэгдүгээрт, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчдийн сонгон шалгаруулалтын захиалгыг хугацаа алдахгүй

ирүүлж, нийтэд нээлттэй зарлахыг Засгийн газарт хандаж зөвлөсөн юм. Хоёрдугаарт, яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар шинээр батлагдах хүртэл халах, чөлөөлөх зэргээр хүний нөөцийн хөдөлгөөн хийхгүй байх талаар яам, агентлагийн удирдлага, тэдгээрийн үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт үүрэг болгосон. Гуравдугаарт, хэрэв бүтцийн өөрчлөлт гарсан тохиолдолд хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг хийхдээ холбогдох хууль, журмын заалтыг баримталж ажиллахыг зөвлөж, хууль тогтоомжийн холбогдох заалтын лавлагаа, тайлбарыг хүргүүлсэн юм.

Энэхүү зөвлөмжийн дагуу яамдын Төрийн нарийн бичгийн даргын ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулалтаар зарлуулах тухай захиалгыг Засгийн газраас 08 дугаар сард, агентлагийн даргын сонгон шалгаруулалтын захиалгыг 10 дугаар сарууддад Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн юм.

Ингэснээрээ Засгийн газар яам, агентлагийн удирдах ажилтныг томилох асуудалд Төрийн албаны тухай хуулийг мөрдөж ажиллан, төрийн албыг хуулийн дагуу явуулах эрмэлзэлтэй байгаагаа харуулсан нь улс төрийн соёлын нэг илрэл мөн.

Төрийн албаны зөвлөл нь Засгийн газраас ирүүлсэн захиалга, зарлагдах ажлын байранд тавигдах шаардлагыг нэг бүрчлэн хэлэлцээд зарим удирдах албан тушаалын ажлын байранд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх талаар санал, зөвлөмж хүргүүлж ажиллав. Засгийн газар Төрийн албаны зөвлөлийн санал, зөвлөмжийг тухай бүрт нь хүлээн авч, ерөнхий болон тусгай шаардлагыг хууль, журамд нийцүүлэн сайжруулж, сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй явуулах нөхцлийг хангаж ажиллав.

Төрийн албаны зөвлөлөөс бүх аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт хандан хууль хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж, санал, албан тоот хүргүүлснээр аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын захиалгаа ирүүлж, тухайн албан тушаалын томилгоог хуульд нийцүүлэх талаар санаачлагатай ажиллаж байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад ахицтай байлаа.

**Төрийн албаны сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ.** 2016 онд Яам, агентлаг, аймаг нийслэл, салбаруудын төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт, семинарт Төрийн албаны зөвлөл оролцож сургалт арга зүйн мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласны зэрэгцээ Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдээс салбарын удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөн, төрийн албан хаагчдын чуулга уулзалт, төсөл, хөтөлбөрийн сургалтуудад ажлын албаны ажилтнууд оролцож ажиллалаа.

Зөвлөлийн ажлын алба байгаа нөөц бололцоогоор ажиллаж ирсэн боловч нэг талаас, төсөв санхүү, хүний нөөцийн хязгаарлагдмал нөхцөл байдлаас болж хүндрэл бэрхшээл үүссэн, нөгөө талаас төрийн албан хаагчдыг сургаж, чадавхижуулах Зөвлөлийн чиг үүрэг хэрэгжихгүй байх нөхцөл байдал зарим талаар үүсээд байна.

Энэ чиг үүргийг цаашид ямар байгууллагаар, хэрхэн хэрэгжүүлэх талаар хууль, эрх зүйн шинэ зохицуулалт шаардлагатай байна. Удирдлагын академийн нөөц бололцоонд түшиглэн

сургалт үйлчилгээний хэрэгжилтийг хангахаар уг Академийн 2017 оны төрийн албан хаагчдын сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран баталдаг уламжлалаа сэргээх бодлого барьж ажиллаа.

Иргэдийг сонгон шалгаруулж төрийн албанд шилж сонгон ажиллуулах, тэднийг сургаж, чадавхижуулах нь хоорондоо салшгүй залгамж үйл явц бөгөөд нэг асуудлын хоёр тал билээ. Энэ агуулгаар авч үзвэл дээрх хоёр чиг үүрэг нь нэгдмэл бодлого, зохицуулалттай нэг байгууллагад байх нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл манай мэт улс оронд зохистой хувилбар байж болох юм.

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10-т “төрийн жинхэнэ албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, зохицуулах”, мөн зүйлийн 35.1.11-т “төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах” гэж тус тус заасныг баримтлан Төрийн албаны зөвлөл, түүний ажлын албаны албан хаагчид төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудад төрийн албаны эрх зүйн зохицуулалт, харилцаа, ёс зүйн чиглэлээр чамгүй олон сургалтыг тайлант жилд зохион байгууллаа.

- Төрийн албаны шинэтгэл
- Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхолын зөрчил
- Ажлын байрны тодорхойлолт боловсруулах арга зүй,
- Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, дүгнэлт гаргах аргачлал,
- Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын зохион байгуулалт,
- Төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах аргачлал, зохицуулалт,
- Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг мэдээлэл болгон гаргах аргачлал гэсэн сэдэвийн хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Шуурхай удирдлагын төвийн бүрэлдэхүүн, нийслэлийн Онцгой байдлын газрын хамт олон, удирдах ажилтнууд, Хил хамгаалах ерөнхий газрын хамт олон, Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтны зөвлөлгөөний албан хаагчид, Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, нийслэлийн Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс зэрэг болон Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд, нийслэлийн Баянгол, Багануур дүүргүүдийн төрийн албан хаагчдын нэгдсэн чуулган, удирдах албан тушаалтны богино сургалтын хүрээнд давхардсан тоогоор 25 байгууллагын 1251 албан хаагчдад ажлын байран дээрх сургалтыг албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаа.

Сургалт хөгжлийн чиглэлээр бэрхшээлтэй гол асуудал бол Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтад байсан "...Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно" гэсэн зохицуулалтад өөрчлөлт орж албан ёсоор сургалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд орон тооны мэргэшсэн албан хаагчдаар бус Зөвлөлийн гишүүд, албан хаагчдын хүч, туршлагад тулгуурлан сургалтыг богино хугацаагаар зохион байгуулж байна.

2015 оны улсын төсвийн хэлэлцүүлгийн явцад Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх сургалт судалгааны нэгжийг татан буулгах саналыг ажлын хэсгээс гаргаж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар татан буулгахаар шийдвэрлэсэн. Энэ шийдвэр нь төсөвт зардлыг багасгах ажлын хүрээнд гарсан хэдий ч Монгол Улсын төрийн алба болон төрийн албан хаагчдын эрх ашигт хохиролтой, бодлогын хувьд эргэж харууштай шийдвэр болсон гэдгийг бид өмнөх тайландаа ч дүгнэн мэдээлсэн.



Төрийн байгууллагын суралцагч байгууллага байх, төрийн албан хаагч мэргэшил, ур чадвараа байнга дээшлүүлж байх эрэлт хэрэгцээ амьдралаас зайлшгүй урган гарсаар байна. Монгол Улсын төрийн алба хөгжиж, албан хаагчид чадавхижих, тогтвортой, ур чадвартай, үр нөлөөтэй байх нэг үндэс нь тасралтгүй сургалт мөн гэдэгтэй маргалдах аргагүй юм. Төрийн байгууллага, албан хаагчдаас төрийн алба, төрийн албан хаагчдын ёс зүй, нийгмийн баталгаа, манлайлал, ур чадварын талаар урт, богино хугацааны сургалт авах, зөвлөгөө авах хүсэлт захиалга өнгөрсөн хугацаанд Төрийн албаны зөвлөлд нилээд ирсэн.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны шинэтгэлийн талаарх тулгамдсан асуудал, сургалт хөгжил, судалгааны чиглэлээр саналыг тухай бүр хэлэлцэн ажлын албаараа дамжуулан зөвлөх үйлчилгээг хүргэж байна.

Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлөөс зарим сумдын Тамгын газрын дарга нарыг төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Цэнгэл, Улаан хус, Толбо зэрэг 10 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг хүлээн авч ажил төрлийн уулзалтыг зохион байгуулан тэдэнд төрийн албаны стандарт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлын талаар зөвлөгөө дэмжлэг үзүүлэв.

Төрийн албаны зөвлөл төрийн албаны тухай хууль тогтоомж стандартыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогыг удирдлагаар хангах зэрэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор яам агентлагийн дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулан "Хүний нөөцийн удирдлага"

сэдэвт арга зүйн сургалтыг 2016 оны 11 дүгээр сард зохион байгуулсан нь байгууллагуудад хүний нөөцийн хөдөлгөөн, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа, сургалт хөгжлийн чиглэлээр нэгдсэн арга зүй, ижил мэдээлэл, ойлголттой байхад ач холбогдолоо өгсөн юм.





Төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх хүрээнд Монголын төрийн албан хаагчдыг Казакстаны Төрийн захиргааны академид сургах хүсэлт тавьж, тус академийн магистрын зэрэг хамгаалах нэг жилийн тусгай хөтөлбөрт сургалтад сургах Хамтын ажиллагааны гэрээг 2016 оны долдугаар сард 3 жилийн хугацаатайгаар байгуулан гэрээний дагуу жил бүр Монгол Улсаас хоёр төрийн албан хаагчийг сургах бөгөөд Казакстаны Төрийн захиргааны академид, тус Улсын Ерөнхийлөгч Н.Назарбаевын нэрэмжит тэтгэлгээр суралцах анхны төрийн албан хаагчдаар Гаалийн ерөнхий газрын Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын улсын байцаагч Б.Байгал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн М.Хулан нар шалгарсан нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах хөгжүүлэх ажлын эхлэл бас ололт болов.

**Зөвлөлийн гадаад харилцаа.** Төрийн албаны зөвлөлөөс 2016 онд гадаад орнуудын төрийн албаны стандартыг судлах, гадаад харилцааг өргөжүүлэх үүднээс дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд: Тайландын вант Улсын Төрийн албаны комиссын гишүүн, Ажлын албаны Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Висоот Прасициривонгсэ тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа, чиг



үүргийн талаар болон төрийн албаны эрх зүйн хүрээнд хийж буй шинэтгэлийн талаар товч танилцуулж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Тус уулзалтын үеэр Төрийн албаны зөвлөл, Тайландын Төрийн албаны комисстой хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Төлөөлөгчдийн Монголд хийх айлчлалын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн гишүүн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ш.Солонго хүлээн авч уулзан, хоёр орны төрийн албаны талаар мэдээлэл солилцлоо.




Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ш.Солонго, Салбар зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нар болон төрийн байгууллагын төлөөлөгчид БНАЛАУ-ын Дотоод хэргийн сайдын урилгаар тус улсад айлчилав. Учир нь БНАЛАУ-д төрийн албаны асуудлууд Дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалд хамаардаг онцлогтой. Айлчлалын үеэр БНАЛАУ-ын яам, агентлагийн удирдах албан тушаалтнуудад “Монгол Улсын төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын онцлог”, “Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, түүнийг дүгнэх тухай”, “Төрийн албан хаагчдын сургалтын стратеги” зэрэг сэдвээр лекц уншиж, санал солилцлоо. Монголчууд гадаад орны ижил төстэй байгууллагын туршлагаас суралцдаг байсан бол энэ удаа хүний нөөцийн удирдлагын асуудлаар өөрийн орны туршлагаа бусадтай хуваалцсан байна. БНАЛАУ-ын Дотоод хэргийн яамныхан Монгол Улсын төрийн албаны төв байгууллагын туршлагаас судлан, суралцах зүйл их байгааг тэмдэглээд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зөвлөх ажилтан ажиллуулах хүсэлт тависан билээ. БНАЛАУ-ын Дотоод хэргийн яам нь тус улсын Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлогтой аж. Айлчлалын үеэр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн төлөөлөгчдийг БНАЛАУ-ын Дотоод хэргийн сайд Камман Сунвилутын, Төрийн сайд, Засгийн газрын ХЭГ-ын дарга Пет Помпипак, БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн дэд дарга Сисай Лхудэтмонсан, БНАЛАУ-Монгол Улсын Засгийн газар хоорондын комиссын Лаосын хэсгийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн сайд Буконг Сихавонг нар хүлээн авч уулзаж Монгол, БНАЛАУ хоорондын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан цаашид хөгжүүлэх, тухайлан төрийн төв байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцов. Талууд Төрийн алба болон эрүүл мэндийн салбарт тодорхой чиглэлүүдээр хамтран ажиллахаар тохиролцов.

Уулзалт, сургалтуудад Монгол Улсаас БНАЛАУ-д суугаа Элчин сайд Л.Галбадрах, Элчин сайдын зөвлөх А.Батсайхан нар оролцов. Энэхүү айчлал нь хоёр орон харилцан туршлага, мэдээлэл солицлон цаашдын хамтын ажиллагааны талаар тодорхой шийдэлд хүрсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Мөн Бүгд Найрамдах Казакстан Улсын нийслэл Астана хотноо болсон Астана дахь бүс нутгийн хамтын ажиллагааны төрийн албаны сүлжээ байгууллагын “Төрийн албаны шинэчлэл,

хамтын ажиллагаа" сэдэвт 2016 оны ээлжит хуралдаанд Төрийн албаны зөвлөлийн төлөөлөл оролцож, "Тогтвортой хөгжилд чиглэсэн мэргэшсэн төрийн алба: ЭЗХАХБ-ын стандарт, зарчмыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэх нь" сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

Бүс нутгийн төрийн албаны энэхүү сүлжээ байгууллагын үйл ажиллагаанд цаашид тогтмол оролцож байх нь тус байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх боломжийг нээж буй төдийгүй төрийн албаны шинэтгэлийн олон улсын туршлагаас суралцах, төрийн албыг чадавхижуулах, төсөл хөтөлбөрт хамрагдах ач холбогдолтой байх юм.

Ийнхүү тайлант он бол Монгол Улсын Төрийн албаны төв байгууллагын гадаад харилцаанд ахиц дэвшил гарсан онцлог жил байлаа.

## *1.3 Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үнэлгээ:*

Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяалах салбарт болон орон нутагт төрийн албаны хууль тогтоомж, Төрийн албаны хууль тогтоомж, Зөвлөлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт ямар байх нь салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанаас шууд хамаарах билээ.

Салбар зөвлөлүүд нь Зөвлөлийн бүтцийн нэгж бөгөөд үйл ажиллагаагаа түүний өмнө хариуцдаг. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3-т "Зөвлөл нь яам, аймаг, нийслэлд салбар зөвлөлтэй байх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, агентлагт салбар зөвлөл ажиллуулах асуудлыг тухайн салбарын болон байгууллагын төрийн албан хаагчдын тоо, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хамрах хүрээ зэргийг харгалзан Зөвлөл шийдвэрлэнэ. Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг Зөвлөл томилно" гэж заасны дагуу Салбар зөвлөлийг байгуулах, бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх эрхийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг.

Салбар зөвлөлүүд нь Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн албаны зөвлөл нь 2016 онд төрийн захиргааны байгууллагын дэргэдэх салбар зөвлөл 26, нутгийн захиргааны байгууллага дахь 22, нийт 48 салбар зөвлөлтэй ажиллаж ирлээ.

| Яамны дэргэдэх Салбар зөвлөл | Агентлаг болон бусад төрийн байгууллагын дэргэдэх Салбар зөвлөл | Аймгууд дахь Салбар зөвлөл | Нийслэл дэх Салбар зөвлөл |
|---|---|---|---|
| 13 | 13 | 21 | 1 |
| НИЙТ 48 САЛБАР ЗӨВЛӨЛ | | | |

"Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоол, "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор зарим яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооны дэргэд шинээр байгуулж, салбар зөвлөлийн дарга, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилсон байна.

Тайлант онд Салбар зөвлөлүүдийн бүрэлдэхүүн 39.5 хувь, салбар зөвлөлүүдийн дарга нарын 81.2 хувь, нарийн бичгийн дарга нарын 39.5 хувь нь өөрчлөгдсөн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний өөрчлөлт 1.1 хувиар буурсан, салбар зөвлөлийн дарга нарын өөрчлөлт 2.4 дахин, нарийн бичгийн даргын өөрчлөлт 1.3 дахин өссөн байна.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдах бүрт яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Агентлагийн дарга нар өөрчлөгдсний улмаас салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дарга, нарийн бичгийн дарга нарын хөдөлгөөн байнга хийгдэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэхгүй байгаагаас харьяа төрийн байгууллагуудад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих ажил зарим талаар орхигдож, хууль тогтоомж, стандарт зөрчих асуудал гарч, салбар зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

Мөн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн орон тооны бусаар ажиллаж байгаагаас төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг чиглэл өгөх асуудал гардаг нь "Өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна" гэсэн эрх зүйн зохицуулалт хэрэгжихгүйд хүрч байгаа тул Салбар зөвлөлийг орон тооны ажилтантай болгох асуудлыг Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах нь зүйтэй байна.

Төрийн албаны зөвлөл нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шилдэг арга барилуудыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам", "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт"-ийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн Яам, агентлаг төрийн байгууллагын дэргэдэх болон аймаг, нийслэл дэх 48 Салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланд үнэлгээ хийж, дүнг ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, ТАЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 67 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолыг нийт 48 салбар зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагаа нь 70-аас доош хувьтай үнэлэгдсэн Салбар зөвлөлүүдэд үйл ажиллагаагаа сайжруулах үүрэг өгч, нийт салбар зөвлөлүүдэд цаашид анхаарч ажиллах асуудлаар зөвлөмж хүргүүлэв.

**Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааны үнэлгээ.** Төрийн албаны зөвлөл 2016 оны эцэст 13 яам, 11 агентлаг, 2 төрийн байгууллага, аймаг нийслэлд 22 нийт 48 салбар зөвлөлтэй ажилласан бөгөөд яамны 12, агентлагийн 7, төрийн байгууллагын 2, аймаг, нийслэлийн 22, нийт 43 Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийлээ.

"Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоол, "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор зарим яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооны дэргэд шинээр байгуулсан бөгөөд байгуулагдсанаас хойш 2-3 сарын хугацаа болж байгаа тул үнэлгээнд хамруулаагүй болно.

Үнэлгээг хийхдээ ажил дүгнэх журмыг баримтлан салбар зөвлөлүүдийг "Яам", "Агентлаг болон төрийн байгууллага", "Аймаг, нийслэл" дэх салбар зөвлөл гэсэн 3 бүлэг болгож, үзүүлэлтүүдийг 0-15 оноогоор үнэлж, дүнг нэгтгэн гаргасан.

**-Яамдаас:** Зам, тээврийн хөгжлийн яам 70.8 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 70.4 хувьтай тус тус дүгнэгдэж эхний байр эзэлсэн байна.

| № | СЗ нэрс | Авбал зохих нийт оноо | Авсан оноо | Үнэлгээ хувь |
|---|---|---|---|---|
| **Яамны дэргэдэх салбар зөвлөл** | | | | |
| 1 | ЗТХЯ | 250 | 177 | 70.8 |
| 2 | ХХААХҮЯ | 250 | 176 | 70.4 |
| 3 | ХЗДХЯ | 250 | 173 | 69.2 |
| 4 | УУХҮЯ | 250 | 171 | 68.4 |
| 5 | БХЯ | 250 | 166 | 66.4 |
| 6 | СЯ | 250 | 164 | 65.6 |
| 7 | ЭХЯ | 250 | 163 | 65.2 |
| 8 | БХБЯ | 250 | 161 | 64.4 |
| 9 | ГХЯ | 250 | 160 | 64.0 |
| 10 | ЭМЯ | 250 | 154 | 61.6 |
| 11 | БОАЖЯ | 250 | 151 | 60.4 |
| 12 | БСШУСЯ | 250 | 150 | 60.0 |
| **Дундаж хувь** | | | | **65.5** |

-**Агентлаг байгууллагаас**: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 72.8 хувь, Гадаадын иргэн харьяатын газар 70.8 хувьтай дүгнэгдэж хангалттай үнэлгээ авчээ.

| № | СЗ нэрс | Авбал зохих нийт оноо | Авсан оноо | Үнэлгээ хувь |
|---|---|---|---|---|
| **Агентлаг, байгууллагын дэргэдэх салбар зөвлөл** | | | | |
| 1 | МХЕГ | 250 | 182 | 72.8 |
| 2 | ГИХГ | 250 | 177 | 70.8 |
| 3 | ЗХЖШ | 250 | 176 | 70.4 |
| 4 | ЦЕГ | 250 | 175 | 70.0 |
| 5 | ХХЕГ | 250 | 173 | 69.2 |
| 6 | Таг.ЕГ | 250 | 172 | 68.8 |
| 7 | ОБЕГ | 250 | 171 | 68.4 |
| 8 | ШЕЗ | 250 | 168 | 67.2 |
| 9 | ШШГЕГ | 250 | 167 | 66.8 |
| **Дундаж хувь** | | | | **69.3** |

-**Аймаг, нийслэлээс:** Орхон аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа **84.4** хувь, Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн үйл ажиллагаа **79.6** хувь, Хэнтий аймаг Салбар зөвлөлийн үйл ажиллагаа **78.0** хувьтай буюу хангалттай гэж дүгнэгдсэн байна.

| № | СЗ нэрс | Авбал зохих нийт оноо | Авсан оноо | Үнэлгээ хувь |
|---|---|---|---|---|
| **Аймаг, нийслэл дэх салбар зөвлөл** | | | | |
| 1 | Орхон | 250 | 211 | 84.4 |
| 2 | Сэлэнгэ | 250 | 199 | 79.6 |
| 3 | Хэнтий | 250 | 195 | 78.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Төв | 250 | 194 | 77.6 |
| 5 | Хөвсгөл | 250 | 190 | 76.0 |
| 6 | Өвөрхангай | 250 | 186 | 74.4 |
| 7 | Нийслэл | 250 | 184 | 73.6 |
| 8 | Дундговь | 250 | 181 | 72.4 |
| 9 | Говь-Алтай | 250 | 178 | 71.2 |
| 10 | Дархан-Уул | 250 | 172 | 68.8 |
| 11 | Дорнод | 250 | 171 | 68.4 |
| 12 | Булган | 250 | 168 | 67.2 |
| 13 | Баянхонгор | 250 | 167 | 66.8 |
| 14 | Говьсүмбэр | 250 | 163 | 65.2 |
| 15 | Завхан | 250 | 160 | 64.0 |
| 16 | Архангай | 250 | 157 | 62.8 |
| 17 | Ховд | 250 | 155 | 62.0 |
| 18 | Увс | 250 | 154 | 61.6 |
| | Дорноговь | 250 | 154 | 61.6 |
| | Өмнөговь | 250 | 154 | 61.6 |
| | Сүхбаатар | 250 | 154 | 61.6 |
| | Баян-Өлгий | 250 | 154 | 61.6 |
| **Дундаж хувь** | | | | **77.6** |

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа **70.8** хувьтай, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа **72.8** хувьтай, Орхон аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа **84,4** хувьтай дүгнэгдэж эхний байруудыг эзэлж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа 60 хувьтай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа 66,8 хувьтай, Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Увс аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа 61,6 хувьтай /хамгийн бага/ үнэлэгдсэн байна.



Салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааны үнэлгээний дунджийг өнгөрсөн жилийн үнэлгээний дундажтай харьцуулан үзвэл яамны дэргэдэх салбар зөвлөлийн үнэлгээ 2,1 хувь, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн үнэлгээний дундаж 5,7 хувь өссөн, аймаг, нийслэл дэх салбар зөвлөлийн үнэлгээний дундаж 8,5 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн албатай холбогдон гарсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх ажлыг чиг үүргийн дагуу зохион байгуулж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг Зам, тээврийн хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймаг дахь салбар зөвлөлүүд сайн зохион байгуулж санаачилгатай ажилласан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар,Увс аймаг дахь салбар зөвлөлүүд санаачилга муутай ажилласан бөгөөд үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.

Орхон, Дорноговь, Булган аймаг дахь салбар зөвлөлүүд хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зорилгоор зөвлөн туслах өдөрлөгийг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, төрийн албан хаагчдыг өргөнөөр хамруулан шинэлэг мэдээ, мэдээллийг өгч, мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулан, төрийн албаны тулгамдсан асуудлыг хэлэлцсэн, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлүүд Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, цаашдын зорилтоо тодорхойлсон. Төв аймаг дахь салбар зөвлөл иргэдээс төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг туршилтын журмаар авч сонирхсон иргэдийн хууль,тогтоомжийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон зэрэг шинэлэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааны үнэлгээнээс үзэхэд дараах чиг үүргийн хэрэгжилтүүд 60 буюу түүнээс доош хувьтай үнэлэгдсэн байна. Үүнд:

- Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагаагаа сурталчилах, Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар зохион байгуулсан шинэлэг үйл ажиллагаа,
- Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэж, түүний мөрөөр зохиосон ажил,
- Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, түүний хэрэгжилтийг тооцсон байдал,
- Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлагналт хангалтгүй байгаатай холбоотой.

Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй үнэлэгдэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж дүгнэж байна. Үүнд:

1. Яам, агентлагийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарын өөрчлөлт хөдөлгөөн нилээд хийгдсэн. Тухайлбал: 2016 онд нийт салбар зөвлөлийн дарга нарын 81,2 хувь /10 яам, 11 агентлаг, байгууллага, 17 аймаг болон нийслэл/-ийг, нарийн

бичгийн дарга нарын 39,5 /7 яам, 5 агентлаг, байгууллага, 7 аймаг/ хувийг тус тус өөрчилсөн байна.

2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөнд нийтлэг болон тусгай чиг үүргийг бүрэн тусгаж хэрэгжүүлэх ажил хангалтгүй,
3. Үйл ажиллагааны тайлагналт, дотоод ажлын зохион байгуулалт сул,
4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангалтгүй зэрэгтэй холбоотой.

Төрийн албаны зөвлөл 2017 онд салбар зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг чадавхижуулах асуудлаар дараах ажлыг хийхээр төлөвлөөд байна. Үүнд

1. Салбар зөвлөлүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг газар дээр нь зохион байгуулах төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх,
2. Тэргүүний ажиллагаатай салбар зөвлөлийн үйл ажиллагаатай бусад салбар зөвлөлийг танилцуулах ажил зохион байгуулах,
3. Салбар зөвлөлийн нийтлэг болон тусгай чиг үүргүүдийг хэрэгжүүлэх асуудлаар аргачилсан гарын авлага бэлтгэж хүргүүлэх,
4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг тайлагнах асуудлаар арга зүйн зөвлөмж өгөх,
5. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг чадавхижуулах талаар сургалт зохион байгуулах,
6. Зарим салбар зөвлөлийн даргын сонсголыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хугацаатай үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

# ХОЁР. ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

## 2.1. Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, томилгоо

Төрийн албаны хүний нөөцийн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг нь бүх шатны төрийн байгууллагын удирдах ажилтныг сонгон шалгаруулах, сургаж бэлтгэх, чадавхижуулах асуудал юм.

Төрийн албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын захиалга хүлээн авах, нийтэд зарлах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэлт гаргах, нэр дэвшүүлэх, томилгоонд нь хяналт тавих нь Төрийн албаны зөвлөлд хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн нэг билээ.

Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ:

- Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6,
- Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйл,
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль,
- Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус баримтлан ажиллаж байна.

Дээрх хууль тогтоомжид зааснаар төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх хоёр үндсэн хэлбэр байдаг. Үүнд:

- ***Нээлттэй сонгон шалгаруулалт***
- ***Албан тушаал дэвшүүлэх сонгон шалгаруулалт***

1. Төрийн захиргааны "Тэргүүн түшмэл", "Эрхэлсэн түшмэл"-ийн ангилалд хамаарах төрийн төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын тэргүүлэх албан тушаал буюу төсвийн шууд захирагчийн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд заавал **нээлттэй сонгон шалгаруулалтыг** явуулахаар хуульчлан заасан. Энэхүү ангиллын албан тушаалууд:

- Улсын Их Хурлаас удирдлагыг нь томилдог, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ажлын албаны болон Тамгын газрын дарга
- Яамдын Төрийн нарийн бичгийн дарга
- Засгийн газрын агентлагийн дарга
- Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга зэрэг нийт 90 шахам удирдах албан тушаалтан буюу төсвийн шууд захирагч байдаг.

Эдгээр удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл хариуцан зохион байгуулдаг юм.

2. Төрийн захиргааны байгууллагын дээр дурдсан удирдах албан тушаалаас **бусад удирдах ажилтны** буюу тухайн байгууллагын бүтцийн нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд "**Албан тушаал дэвшүүлэх зарчим"-**аар буюу тухайн байгууллагад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчдаас 2-оос доошгүй хүнийг сонгон нэр дэвшүүлж, тэдгээрээс тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг хэн нь илүү хангаж байгаа талаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гарган сонгон шалгаруулахаар хуульчилсан байдаг.

Энэ ангиллын удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын нэг хэсгийг нь Төрийн албаны зөвлөл, бусдыг нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд зохион байгуулж явуулахаар Улсын Их Хурлаас баталсан журмаар зохицуулсан байдаг. Тухайлбал, Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, түүнчлэн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын Ажлын албаны дотоод бүтцийн бүх нэгжийн удирдах албан тушаал, яам, агентлагийн зөвхөн газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл хариуцан зохион байгуулах үүрэгтэй.

## *А. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын талаар.*

Төрийн албаны зөвлөл дээр дурьдсан чиг үүргийнхээ хүрээнд 2016 онд давтагдсан тоогоор 24 байгууллагын 52 ажлын байрны захиалгыг хүлээн авч, тус бүрт нь нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулав.

Ингэхдээ томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн захиалга, ажлын байранд тавигдсан шаардлагын талаар тухайн албан тушаалуудад томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар тухай бүрт хэлэлцэж, захиалгыг нийтэд зарлах эсвэл захиалагчид буцаах шийдвэр гарган ажиллав. Сонгон шалгаруулах зарыг тус Зөвлөлийн www.csc.gov.mn цахим хаягаар ажлын 21-ээс доошгүй хоногийн өмнө нийтэд нээлттэй зарлан мэдээлж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ирлээ.

Дээрх зарлагдсан 52 удирдах албан тушаалуудад Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам", Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор баталсан сонгон шалгаруулалтын үнэлгээний зааврын дагуу өрсөлдөхөөр тухайн ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан **99** иргэн бүртгүүлснээс **76** иргэн шалгалтад тэнцсэн байна. Тэднээс **52** иргэнийг тухайн өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар Төрийн албаны зөвлөл дүгнэлт гаргаж, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал болгосон шийдвэр гаргаж, **24** иргэнийг удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэх тогтоол гаргажээ.

Удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын сүүлийн 10 жилийн дүн мэдээг харьцуулбал:

| Үзүүлэлт | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТАЗ-ийн дүгнэлт гаргаж нөөцөд бүртгэгдсэн хүний тоо | 27 | 65 | 228 | 31 | 36 | 32 | 110 | 34 | 76 | 76 |
| ТАЗ-өөс нэр дэвшүүлсэн хүний тоо | 27 | 65 | 39 | 38 | 12 | 17 | 76 | 24 | 34 | 52 |
| Зарлагдсан албан тушаалд томилогдсон иргэд | 8 | 18 | 39 | 12 | 12 | 17 | 69 | 18 | 31 | 52 |

Өмнөх оныхтой харьцуулахад нээлттэй сонгон шалгаруулалтад орж өрсөлдөхөөр бүртгүүлсэн иргэдийн тоонд төдий л өөрчлөлт гараагүй байна. Харин томилогдсон албан тушаалтны тоо 18-аар илүү байна. Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд өмнөх жилүүдэд Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гарган нэр дэвшүүлсэн иргэнийг тухайн албан тушаалд нь томилохгүй байх тохиолдол багагүй гардаг байсан бол тайлант онд ийм тохиолдол гараагүй нь нэг дэвшил юм.

Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлсэн 52 иргэнийг Засгийн газар болон томилох эрх бүхий албан тушаалтан тухайн удирдах албан тушаалд томилсон нь үүнийг нотолно.

### *Засгийн газар ба төрийн төв байгууллагын захиалын хүрээнд:*

Засгийн газар яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга гэсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн шууд захирагч нарыг томилдог бөгөөд эдгээр албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд ирүүлэх хуулийн зохицуулалтын дагуу давхардсан тоогоор **31** удирдах албан тушаалын сул орон тоог нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөх захиалга ирүүлсэн байна. Зохих албан тушаалд Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалт явуулж, дүгнэлт гарган нэр дэвшүүлжээ. Үүнд:

| д/д | Захиалга ирүүлсэн байгууллагын нэр | Сонгон шалгаруулалт явагдсан албан тушаалын нэр | Сонгон шалгаруулалт явагдсан албан тушаалын тоо | Бүртгүүлсэн иргэний тоо | Тэнцсэн иргэний тоо | Нэр дэвшиж томилогдсон иргэний тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Засгийн газар | Яамдын Төрийн нарийн бичгийн дарга | 11 | 22 | 18 | 11 |
| | | Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга | 3 | 5 | 3 | 3 |
| | | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга | 13 | 26 | 18 | 13 |
| 2 | Аж үйлдвэрийн сайд | Цагааннуур чөлөөт бүсийн захирагч | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Улсын Их Хурлын Тамгын газар | Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн дарга | 1 | 1 | 1 | 1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Санхүүгийн зохицуулах хороо | Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт, үйлчилгээний хэлтсийн дарга | 1 | 1 | 1 | 1 |
| 5 | Хүний эрхийн үндэсний комисс | Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга | 1 | 1 | 1 | 1 |
| **Нийт** | | | **31** | **57** | **43** | **31** |

Яамд /түүний харьяа газар/-ын газар, хэлтсийн даргын удирдах ажилтны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн нарийн бичгийн дарга Төрийн албаны зөвлөлд ирүүлдэг зохицуулалтын дагуу 2016 онд 2 яам /харьяа газар/-ны 4 удирдах албан тушаалын ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалтын захиалга ирснийг Төрийн албаны зөвлөл нийтэд нээлттэй зарлан, шалгалтыг зохион байгуулахад 10 иргэн сонгон шалгаруулалтад өрсөлдөн 8 иргэн нөөцөд бүртгэгдэн 4 нь тухайн албан тушаалдаа томилогдсон юм.

| д/д | Захиалга ирүүлсэн байгууллагын нэр | Сонгон шалгаруулалт явуулсан албан тушаалын нэр | Бүртгүүлсэн иргэний тоо | Тэнцсэн иргэний тоо | Нэр дэвшиж томилогдсон иргэний тоо |
|---|---|---|---|---|---|
| **1** | Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга | 1 | 1 | 1 |
| | | Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга | 2 | 2 | 1 |
| **2** | Хууль зүй дотоод хэргийн яам | ХЗДХ-ийн сайдын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга | 1 | 1 | 1 |
| | | ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн захирал | 6 | 4 | 1 |
| НИЙТ | | | **10** | **8** | **4** |

***Аймаг, нийслэлээс ирүүлсэн захиалгын хүрээнд:***

Нийслэл, орон нутгаас 11 удирдах албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөхөх нээлттэй сонгон шалгаруулалтын захиалга ирсэн байна. Зохих албан тушаалд Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалт явуулж, дүгнэлт гарган нэр дэвшүүлжээ. Нийслэл болон Ховд, Увс, Хэнтий, Архангай, Төв, Говьсүмбэр, Орхон, Говь-Алтай, Дорноговь зэрэгаймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд 26 иргэн бүртгүүлж 18 иргэн тус тус тэнцсэн бол 11 иргэн нь тухайн албан тушаалдаа томилогдож, 7 нь удирдах ажилтны нөөцөд бүртгэгдсэн.

| д/д | Сонгон шалгаруулалт явагдсан албан тушаалын нэр | Сонгон шалгаруулалт явагдсан албан тушаалын тоо | Бүртгүүлсэн иргэний тоо | Тэнцсэн иргэний тоо | Нэр дэвшиж, томилогдсон иргэний тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга | 11 | 26 | 18 | 11 |
| 2 | Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга | 5 | 5 | 5 | 5 |
| **Нийт** | | **17** | **32** | **24** | **17** |

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын хүрээнд нийслэл, Говьсүмбэр, Увс, Хэнтий, Орхон аймгийн 5 албан тушаалд тус бүрт нэг хүн бүртгүүлж, шалгалт өгснөөс, бүгд сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж албан тушаалдаа томилогдсон.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захиалгаар Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зохих ёсоор зохион байгуулагдаж томилгоо хийгдсэн.

Ийнхүү 2016 онд яамны Төрийн нарийн бичгийн дарга 11, Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн дарга 16, Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга 1, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга 11, аймаг, нийслэлийн



ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 5, төрийн захиргааны бусад байгууллагын удирдах ажилтны 8 ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтад нийт 99 иргэн бүртгүүлж шалгагдсанаас **76** иргэн тэнцэж, үүнээс **52** нь албан тушаалдаа нэр дэвшин томилогдож, **24** нь удирдах ажилтны нөөцөд бүртгэгджээ.

Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалтын дүнг тухай бүр www.csc.gov.mn цахим хуудсаараа нийтэд нээлттэй мэдээлж, комиссын тайлан, дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж, удирдах албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх, нөөцөд бүртгэх, шийдвэрүүдийг гаргасан.

### *Б. Албан тушаал дэвшүүлэх зарчмаар удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулсан талаар.*

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а, б"-д заасныг тус тус баримталж төрийн захиргааны төв байгууллагын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтанд 2-оос доошгүй хүнийг сонгон нэр дэвшүүлж,Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, томилох эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлдэг билээ.

***Энэ зарчмын дагуу 2016 онд нийт төрийн захиргааны 32 байгууллагын удирдах ажилтны 90 албан тушаалд нэр дэвшүүлсэн 182 албан хаагчдаас тус тус сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах захиалгыг Төрийн албаны зөвлөл хүлээн авч гүйцэтгэлээ.***

Ийнхүү төрийн жинхэнэ албаны ахлах болон эрхэлсэн түшмэлийн удирдах албан тушаалтны сул орон тоог нөхөхөөр төрийн байгууллагаас нэр дэвшүүлж ирүүлсэн албан хаагчдаас Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалт хийж, дүгнэлт гаргахдаа дээрх журамд заасан дараах шалгуурыг голлох үндэслэлээ болгодог. Үүнд:

- Тухайн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн;
- Төрийн жинхэнэ албан тушаалд бэлтгэгдсэн байдал;
- Ажлын туршлага, ёс зүйн байдал;
- Мэргэжлийн түвшин, мэргэших сургалтад хамрагдсан байдал;
- Тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заагдсан бусад шаардлагыг хангасан байдал гэх мэт.

Төрийн байгууллагуудын төсвийн шууд захирагч болон хуулинд нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөхөөр зааснаас бусад удирдах албан тушаалтанд дээрх журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдаас нэр дэвшүүлэн сонгон шалгаруулж, албан тушаал дэвшүүлэх зарчмаар томилох нь төрийн албаны ***"Мерит"*** тогтолцоо бүрдүүлэх нэг чухал алхам билээ.

Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн захиалгыг байгууллагуудаар нь авч үзвэл:

**1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс** удирдах ажилтны **15** албан тушаал /Улсын Их Хурлын Тамгын газрын 10, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 4, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1/-ын сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар 30 албан хаагчийн;

**2. Яамдуудын 43 удирдах албан тушаалын** сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар 13 яамны 86 албан хаагчийн;

**3. Засгийн газрын тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлагийн 32 удирдах албан тушаалын** сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар 13 агентлагийн 64 албан хаагчийн материалыг тус тус ирүүлжээ.

Зөвлөл тухай бүрт нь дүгнэлт гаргах комисс томилж, дүнг хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргасан албан тушаалтнууд бүгд томилогдсон байна.

Ийнхүү тайлант онд төрийн захиргааны 90 удирдах албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчдаас албан тушаал дэвшүүлэх замаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж буй нь төрийн албанд боловсон хүчний мэргэшсэн, тогтвортой, залгамж чанарын бодлого, зарчмыг хэрэгжүүлсэн нэг чухал хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, шинэ Засгийн газар удирдах албан тушаалын томилгоонд төрийн албаны хуулийг мөрдөн ажиллаж буйн тод жишээ мөн.




Дээрх байгууллагуудаас нэр дэвшүүлсэн албан хаагчдад дүгнэлт гаргах комиссыг Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар томилж, нэр дэвшигчдээс 1 албан хаагчийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах ажлыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж ирэв. Комиссын дүнг тухай бүр Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт шийдвэр гаргаж ажиллав.

## 2.2 Төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалга, нөхөн хангалт

Төрийн албаны зөвлөл нь хууль тогтоомжоор хүлээлгэсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын ажлын байранд тавигдсан шаардлагыг хангах мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, ур чадвартай иргэнийг шударгаар, нээлттэй өрсөлдүүлэх замаар сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Энэхүү хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

### А. Сул орон тооны захиалга, түүний хангалтыг зохион байгуулах талаар:

Төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөл хүлээн авч бүртгэн, ажлын байранд тавигдах шаардлагуудыг хянан үздэг. Байгууллагаас ирүүлсэн захиалга шаардлагад нийцэж буй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17.4 дэх хэсэгт заасныг үндэслэн өмнө нь төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, нөөцөд бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих шаардлагыг харгалзан сонгон шалгаруулж нөхөх боломж, бололцоог бүрдүүлэх үүднээс www.csc.gov.mn гэсэн цахим хуудасны **"Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц → Нөөцөөс нөхөх иргэдийн зар"** гэсэн хэсэгт ирүүлсэн захиалгын тухай дэлгэрэнгүй мэдээлэл бүхий зарыг байршуулан нийтэд тухай бүр зарлаж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллав.

Ингээд зарлагдсан сул орон тоо зарлалд заасан хугацаанд нөөцөд бүртгэлтэй иргэдээс захиалга нөхөгдөөгүй буюу захиалга хангагдаагүй тохиолдолд тухайн ажлын байрны сул орон тооны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий зарыг **www.csc.gov.mn** гэсэн цахим хуудасны **"Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт → Мэргэшлийн шалгалтын зар, мэдээлэл"** гэсэн хэсэгт шалгалт эхлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө байршуулан нийтэд зарлан мэдээлэв. Энэ нь төрийн албанд орох хүсэлтэй иргэдэд мэдээлэлтэй танилцах, өөрийгөө бэлтгэх боломж олгож байгаа төдийгүй, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлж буй илрэл юм.

***Төрийн албаны зөвлөл нь 2016 онд төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас нийтдээ 544 /давхардсан тоогоор/ ажлын байрны сул орон тоог нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөх захиалга хүлээн авчээ.***

Өнгөрсөн онд нийтэд нээлттэй зарлагдсан төрийн жинхэнэ албаны сул орон тооны 98 орчим хувь буюу 534 нь аймгаас, үлдсэн 10 нь төрийн захиргааны төв болон түүний харьяа байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалга байлаа. Үүнийг тус бүрээр авч үзвэл:

***Төрийн захиргааны төв байгууллагын мэдээ:***

2015 онд 20 ажлын байрны сул орон тоог нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулсан бол **2016** онд төрийн захиргааны төв байгууллагуудаас нийтдээ **10** ажлын байрны

сул орон тоог нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөх захиалга хүлээн авсан байна. Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар"-ыг баримталж Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журмын 3 дугаар зүйлийн 20 дахь заалтын дагуу тухай бүр Комисс томилогдон ажиллаж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг нийтдээ 5 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, захиалгын дагуу нийт **6** байгууллагын **10** сул орон тоо нийтэд нээлттэй зарлагдаж **1356** иргэн бүртгүүлж, **484** иргэн шалгалтад тэнцэж үүнээс **9** иргэн өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авч, нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж, сул орон тоог нөхөн хангалт хийсэн байна.

Хэдийгээр шалгалт бүрэн цахим хэлбэрт шилжиж, гомдол маргаан гарахгүй болсон боловч "Үйл ажиллагааны ил тод байдал"-ыг улам хангах үүднээс шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан харах боломжийг бүрдүүлэн, орон нутаг дахь бүх салбар зөвлөлд нэвтрүүлэн ажилласан.

Төрийн албаны зөвлөлөөс харьяаллын дагуу өөр дээрээ зохион байгуулсан анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг байгууллага тус бүрээр нь авч үзвэл:

| № | Байгууллагууд | Зарлагдсан ажлын байрны сул орон тоо | Мэргэшлийн шалгалт зохион байгуулсан тоо | Бүртгүүлсэн хүний тоо | Шалгалтад тэнцсэн хүний | | Өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авч нэр дэвшсэн хүний тоо | Ажлын байр нөхөгдсөн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Хувь | | |
| 1 | Улсын Их Хурлын Тамгын газар | 1 | 1 | 16 | 6 | 37.50% | 1 | 100% |
| 2 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам | 1 | 1 | 7 | 3 | 42.85% | 1 | 100% |
| 3 | Зам, тээврийн хөгжлийн яам | 4 | 1 | 59 | 22 | 37.28% | 3 | 75% |
| 4 | Гадаадын иргэн, харьяатын газар | 2 | 1 | 10 | 7 | 70.00% | 2 | 100% |
| 5 | Санхүүгийн зохицуулах хороо | 1 | | 1257 | 441 | 35.08% | 1 | 100% |
| 6 | Хууль зүй, дотоод хэргийн яам | 1 | 1 | 7 | 5 | 71.42% | 1 | 100% |
| **НИЙТ** | | **10** | **5** | **1356** | **484** | **35.69%** | **9** | **90%** |

***Аймгууд дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүн мэдээ:***

2016 онд төрийн жинхэнэ албан тушаалын **534** /давхардсан тоогоор/ сул ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаж, **3880** иргэн бүртгүүлж, **1344** иргэн төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцэж, **302** иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор нэр дэвшин, өрсөлдсөн албан тушаалдаа томилогдсон байна.

Аймаг тус бүрээр мэргэшлийн шалгалтын дүн мэдээг авч үзвэл:

| № | Аймаг | Мэргэшлийн шалгалт зохион байгуулсан тоо | Нийтэд зарласан сул орон тоо | Бүртгүүлсэн иргэд | Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэдийн тоо | | Хүн бүртгүүлээгүй сул үлдсэн орон тоо | Шалгалтаар хүн тэнцээгүй сул үлдсэн орон тоо | Нэр дэвшсэн иргэний тоо | Ажлын байр нөхөгдсөн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 2 | 10 | 145 | 53 | 37.20% | 2 | - | 8 | 80.00% |
| 2 | Баян-Өлгий | 1 | 3 | 38 | 19 | 50.00% | - | - | 3 | 100% |
| 3 | Баянхонгор | 1 | 35 | 164 | 45 | 27.43% | 6 | 13 | 16 | 45.71% |
| 4 | Булган | 2 | 44 | 378 | 153 | 40.47% | 3 | 8 | 33 | 75.00% |
| 5 | Говь-Алтай | 1 | 40 | 149 | 49 | 32.88% | 11 | 11 | 18 | 45.00% |
| 6 | Говьсүмбэр | 1 | 19 | 129 | 37 | 28.68% | 3 | 10 | 6 | 31.57% |
| 7 | Дархан-Уул | 1 | 13 | 94 | 34 | 36.17% | 1 | 2 | 10 | 76.92% |
| 8 | Дорноговь | 2 | 72 | 232 | 76 | 32.75% | 13 | 22 | 37 | 51.38% |
| 9 | Дорнод | 2 | 17 | 205 | 102 | 49.75% | - | 3 | 14 | 82.35% |
| 10 | Дундговь | 2 | 23 | 168 | 60 | 35.71% | 3 | 6 | 14 | 60.86% |
| 11 | Завхан | 1 | 6 | 65 | 17 | 26.15% | - | 2 | 4 | 66.66% |
| 12 | Орхон | 2 | 21 | 92 | 25 | 27.17% | 6 | 8 | 7 | 33.33% |
| 13 | Өвөрхангай | 1 | 27 | 223 | 81 | 36.32% | 5 | 7 | 15 | 55.55% |
| 14 | Өмнөговь | 3 | 69 | 383 | 109 | 28.45% | 10 | 29 | 30 | 43.47% |
| 15 | Сүхбаатар | 1 | 11 | 72 | 12 | 16.66% | - | 4 | 7 | 63.63% |
| 16 | Сэлэнгэ | 2 | 48 | 498 | 163 | 32.73% | 15 | 8 | 25 | 52.08% |
| 17 | Төв | 1 | 13 | 123 | 21 | 17.07% | 2 | 5 | 6 | 46.15% |
| 18 | Увс | 2 | 18 | 76 | 32 | 42.10% | 8 | 1 | 9 | 50.00% |
| 19 | Ховд * | - | - | - | - | - | - | - | - | - |
| 20 | Хөвсгөл | 2 | 32 | 433 | 173 | 39.95% | - | 4 | 28 | 87.50% |
| 21 | Хэнтий | 2 | 13 | 213 | 83 | 38.96% | 1 | - | 12 | 92.30% |
| **Нийт** | | **32** | **534** | **3880** | **1344** | **34.63%** | **89** | **143** | **302** | **56.55%** |

** Ховд аймаг дахь салбар зөвлөлөөс 2016 онд мэргэшлийн шалгалтыг зохион байгуулаагүй*

### *Б. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтаар хүн бүртгүүлээгүйн улмаас үлдсэн ажлын байрны талаар:*

Өнгөрсөн онд аймгуудад нийтэд нээлттэй зарлагдсан 534 /давхардсан тоогоор/ төрийн жинхэнэ албаны сул орон тооноос **46** ажлын байрыг 1-7 удаа зарласан боловч иргэд бүртгүүлээгүй үлдсэн байна. Иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны талаарх судалгааг аймаг дахь Салбар зөвлөлүүдээс гаргуулж, дүнг авч үзвэл:

- Аймгуудын Эрүүл мэндийн газарт **17** ажлын байр;
- Аймгуудын Мэргэжлийн хяналтын газарт **5** ажлын байр;
- Аймгуудын Нийгмийн даатгалын хэлтэст **2** ажлын байр;
- Сумдын ЗДТГ-ын Мал эмнэлэг, үржлийн тасагт **8** ажлын байр;
- Аймаг, сумдын Байгаль хамгаалагч **3** ажлын байр;
- Бусад байгууллагад /Боловсрол, соёлын газарт 2, зарим сумдын ЗДТГ-т газрын даамал 4, усны нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, бэлчээр, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн 3, төрийн сангийн мэргэжилтэн 1 гэх мэт/

Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл:

- Их эмч /хүний их эмч, хүүхдийн эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч, эрүүл ахуйч, тархвар судлаач, эм зүйч, нийгмийн эрүүл мэндийн судлаач/ мэргэжлийн шаардлага тавигдсан **24** ажлын байр
- Малын эмч, мал зүйч, мал аж ахуйн чиглэлийн мэргэжлийн шаардлага тавигдсан **8** ажлын байр
- Инженер /газар зохион байгуулалт, газрын кадастр, гидрогеологи/ мэргэжлийн шаардлага тавигдсан **4** ажлын байр
- Боловсрол, орос англи хэлний багш, дуу хөгжмийн багш мэргэжлийн шаардлага тавигдсан **2** ажлын байр
- Бусад /байгаль хамгаалал, экологи, хөдөө аж ахуй, агрономи, бараа таваар судлаач/ **8** ажлын байр байгаа нь дээрх мэргэжлийн хүмүүс орон нутагт хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Дээрх сул орон тоо бүхий ажлын байранд иргэд бүртгүүлэхгүй байгаагийн шалтгааныг авч үзвэл **Нэгд,** тухайн ажлын байранд тавигдсан шаардлагад нийцэх боловсрол, мэргэжил, туршлагатай боловсон хүчин орон нутагт хүрэлцэхгүй, **Хоёрт**, цалин хөлс бага, **Гуравт,** хөдөө орон нутаг, алслагдсан сумдад тогтвор, суурьшилтай ажиллах хүсэл сонирхолтой иргэн цөөн байгаатай холбоотой ажээ.

Иргэд бүртгүүлэхгүй байгаа орон тоог хэрхэн нөхөх талаар: /аймгуудаас ирүүлсэн санал/

- Эрүүл мэнд, хөдөө аж ахуйн чиглэлээр чиглэлээр их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудтай гэрээ байгуулах;
- Нийгмийн баталгааг хангах, цалин нэмэгдүүлэх;
- Төрийн үйлчилгээний ангилалд шилжүүлэх;
- Байгаль хамгаалагчийн ажлын байрыг төрийн захиргааны албан тушаалын ангиллаас гаргах, гэрээт ажилтан болгох зэрэг санал ирсэн байна.

Бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт байнгын булан нээж, зард тавигдсан мэдээллийн дагуу тухайн албан тушаалд ажиллахыг сонирхсон этгээд төрийн жинхэнэ албан хаагч бол Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, нөөцөд байгаа иргэн бол нөөцөөс нэр дэвшүүлэх журмын дагуу, шалгалт өгөөгүй иргэний хувьд тухай бүр нь төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулах замаар уг сул орон тоог нөхөх арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

### *B. Төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулсан талаар:*

Төрийн албаны зөвлөл нь мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар”-ыг баримталж ажиллахыг аймаг, нийслэл дэх шалгалтын Салбар

комисст үүрэг болгож, тухай бүр хяналт тавих, мэргэшил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж ажиллав.

Төрийн жинхэнэ албаны ажлын байранд тавигдах нэг шаардлага бол гадаад хэлний мэдлэг байдаг. Төрийн захиргааны төв байгууллагуудаас ирүүлсэн захиалгын зарим ажлын байранд англи хэлний мэдлэгийн тусгай шаардлага тавигдсан тохиолдолд тухайн ажлын байранд бүртгүүлсэн иргэдээс англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт зохион байгуулалтын асуудлыг тодорхой зохицуулалтаар хангаж ажиллав.

Гадаад оронд суралцаж Бакалавр зэрэгтэй төгссөн, эсхүл Магистр, Докторын ажлаа англи хэлээр бичиж хамгаалсан, мөн "TOEFL", "IELTS"-ийн түвшин тогтоох шалгалтын баталгаажсан дүнтэй иргэдийг англи хэлний шалгалтаас чөлөөлж байна.

Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалт цахим хэлбэрт бүрэн шилжсэнээр шалгуулагч иргэдээс мэргэшлийн шалгалтын зохион байгуулалт болон үнэлгээтэй холбоотойгоор гомдол маргаан гараагүйг онцлон тэмдэглэж байна.

Хэдийгээр шалгалт бүрэн цахим хэлбэрт шилжиж, гомдол маргаан гарахгүй болсон боловч "Үйл ажиллагааны ил тод байдал"-ыг улам хангах үүднээс шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан харах боломжийг нийт орон нутаг дахь салбар зөвлөлүүдэд бүрэн нэвтрүүлж ажиллалаа.

***2016 онд Төрийн жинхэнэ албан тушаалын 544 /давхардсан тоогоор/ сул ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаж, 5236 иргэн бүртгэж, 1828 иргэн төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгджээ.***

Төрийн албаны мэргэшлийн шалгалт авч эхэлснээс хойших 20 жилийн тоо мэдээг дараах хүснэгтэд үзүүлэв.

| Он | Зарласан ажлын байрны тоо | Шалгалт өгсөн хүний тоо | Тэнцсэн хүний тоо | Хувь | Өрсөлдсөн ажлын байрандаа нэр дэвшсэн хүний тоо | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1997 | 829 | 1067 | 528 | 71.20% | 388 | 75.40% |
| 1998 | 1406 | 1717 | 1092 | 49.50% | 888 | 73.50% |
| 1999 | 842 | 1318 | 815 | 63.60% | 572 | 81.30% |
| 2000 | 832 | 1608 | 870 | 61.80% | 549 | 70.20% |
| 2001 | 1213 | 2423 | 1395 | 54.10% | 911 | 63.10% |
| 2002 | 1488 | 2656 | 1718 | 57.60% | 818 | 65.30% |
| 2003 | 892 | 2799 | 1988 | 64.70% | 435 | 47.60% |
| 2004 | 640 | 3047 | 1309 | 71.00% | 752 | 21.90% |
| 2005 | 970 | 4024 | 1829 | 43.00% | 970 | 57.40% |
| 2006 | 1968 | 4719 | 1968 | 45.50% | 1180 | 53.00% |
| 2007 | 927 | 3601 | 847 | 41.70% | 300 | 60.00% |
| 2008 | 2045 | 8133 | 2444 | 23.50% | 920 | 35.00% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2009 | 4862 | 25450 | 12241 | 30.10% | 4723 | 37.60% |
| 2010 | 907 | 4573 | 3104 | 48.10% | 796 | 38.60% |
| 2011 | 1009 | 5300 | 3705 | 69.91% | 1167 | 31.50% |
| 2012 | 1065 | 6280 | 3647 | 58.07% | 1207 | 33.09% |
| 2013 | 1489 | 9732 | 1999 | 20.00% | 1073 | 53.60% |
| 2014 | 1997 | 13618 | 3475 | 26.00% | 1113 | 32.00% |
| 2015 | 1091 | 10209 | 2790 | 27.30% | 790 | 28.30% |
| **2016** | **544** | **5236** | **1828** | **34.91%** | **311** | **17.01%** |

2016 оны үзүүлэлтийг өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад сул орон тооны захиалгаар хамгийн цөөн боловч мэргэшлийн шалгалтад хамрагдсан хүнийхээ тоогоор 7-рт байгаагаараа нэлээд ачаалалтай жил байсан нь харагдана.

## 2.3. Төрийн албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэлт

Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн сан нь албан тушаал эрхэлж байгаа болон нөөцөд байгаа албан хаагчаас гадна төрийн албанд анх орохоор мэргэшлийн шалгалт өгч, нөөцөд бүртгэгдсэн иргэдээс бүрддэг.

Төрийн албаны төв байгууллагын үндсэн чиг үүргийн нэг нь төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний улсын хэмжээний нөөцийн санг бүрдүүлэх, уг нөөцийн сангаас төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөн хангах үйл ажиллагаа байдаг билээ.

Энэ үйл ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн албаны зөвлөлөөс 2009 онд баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тус журам нь төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санг бүрдүүлэх, нөөцөд бүртгэх, нөөцөөс хасах, нөөцөөс нэр дэвшүүлэх, нөөцийн сангийн бүртгэл хөдөлгөөнийг хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.

### А. Төрийн албанд анх орох иргэний нөөцийн сангийн бүрдүүлэлтийн талаар:

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санг төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэдээр нөхөн бүрдүүлдэг.

***Дээрх журмын дагуу 2016 онд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт төв, орон нутагт 37 удаа зохион байгуулагдаж, шалгалтад тэнцсэн 1828 иргэн Төрийн албанд анх орох иргэний нөөцөд шинээр бүртгэгдсэн байна.***

Үүнийг өмнөх жилийн тоо мэдээтэй харьцуулбал:

| № | Он | Зарласан ажлын байрны тоо | Шалгалт өгсөн иргэний тоо | Шалгалтад тэнцсэн иргэн | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоо | хувь |
| 1 | 2010 | 907 | 4573 | 3104 | 48.1% |
| 2 | 2011 | 1009 | 5300 | 3705 | 69,91 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 2012 | 1065 | 6280 | 3647 | 58,07 |
| 4 | 2013 | 1489 | 9732 | 1999 | 20.5% |
| 5 | 2014 | 1997 | 13618 | 3475 | 26% |
| 6 | 2015 | 1091 | 10209 | 2790 | 27.30% |
| 7 | **2016** | **544** | **5236** | **1828** | **34.91%** |

**2015-2016** онуудад төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд 4618 иргэн шалгалт өгч тэнцэн бүргэгдсэнээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авч тухайн албан тушаалдаа шууд томилогдсон болон нөөцөөс нэр дэвшүүлэх журмын дагуу 1503 иргэн төрийн жинхэнэ албан тушаалд томилогдож, одоо нөөцөд **3115** иргэн байна.

Тоо мэдээнээс үзвэл 2015, 2016 оныг харьцуулахад шалгалт өгсөн иргэдийн тоо 4973 орчимоор буурсан нь сул ажлын байрны захиалга өмнөх оныхоос 2 дахин буурч цөөрсөнтэй холбоотой. Нийт бүртгүүлсэн иргэдээс шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо өмнөх оноос 7.61 хувиар өсөж 34.91 хувьд хүрсэн нь чанарын хувьд дээшилсэн үзүүлэлтийг харуулж байна.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан нэгдсэн шалгалтууд 2016 онд техник технологийн дэвшилд тулгуурлан цахим хэлбэрээр явагдсан бөгөөд мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу "Үйл ажиллагааны ил тод байдал"-ыг улам хангах үүднээс шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан харах боломжийг бүх аймгуудад нэвтрүүлж, шалгалт хөндлөнгийн нөлөөлөл, хүний зүй бус оролцооны боломж бүрэн хаагдсан юм.

Төрийн албанд анх орох иргэний нөөцийн сангийн бүрэлдэхүүн байнгын хөдөлгөөнд байдаг. Энэ хөдөлгөөн нь орох, гарах гэсэн 2 чиглэлтэй. Нөөцөөс хасагдах буюу гарах хөдөлгөөн нь дараах хэлбэртэй байдаг. Үүнд:

- Нөөцөд байх хүчинтэй хугацаа /2 жил/ дуусгавар болох,
- Төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшин томилогдох,
- Нөөцийн жагсаалтаас хасуулахаар өөрөө хүсэлт гаргах,
- Бусад тодорхой шалтгаанаар нөөцөд байх шаардлагагүй болсон г.м

## *Б. Нөөцөөс нэр дэвшүүлэн томилсон байдал:*

Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх нэг хэлбэр нь Төрийн байгууллагын захиалгыг үндэслэн төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөөс дүгнэлт гарган нэр дэвшүүлэн төрийн жинхэнэ албанд томилох ажиллагаа байдаг.

Нөөц бүрдүүлэх журамын 5.1-д зааснаар: Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17.4 дэх хэсэгт заасныг үндэслэн дээрх нөөцийн сангаас тухайн сул орон тоог нөхөх тухай захиалгаа төрийн байгууллагууд Төрийн албаны зөвлөл болон түүний салбар зөвлөлд ирүүлжээ.

***Энэ захиалгын дагуу 2016 онд Төрийн албаны зөвлөл, аймаг нийслэл дэх салбар зөвлөлөөс нийт 446 иргэнийг нөөцөөс нэр дэвшүүлж, төрийн жинхэнэ албан тушаалд томилуулжээ.***

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тус тусын харьяалалын дагуу нөөцийн сангаас нэр дэвшүүлэх ажиллагааг зохион байгуулдаг. Дээрх тоог төв, орон нутгаар ялган үзвэл:

- 171 иргэнийг төрийн төв байгууллагууд,
- 96 иргэнийг аймаг, орон нутаг дахь төрийн захиргааны байгууллагууд,
- 179 иргэнийг нийслэл дэх төрийн захиргааны байгууллагууд тус тус захиалга ирүүлж төрийн албан хаагчийн нөөцөөс нэр дэвшүүлж томилжээ.

## *Нөөцөөс нэр дэвшүүлэн томилогдсон байдлыг байгууллагаар нь авч үзвэл:*

### *Төрийн төв байгууллагууд:*

Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагаас нийтдээ 33 сул орон тоон дээр захиалга ирүүлснийг судлан үзээд, 26 иргэнийг дүгнэлт гарган нөөцөөс нэр дэвшүүлснийг тухайн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан тушаал гарган томилгоо хийжээ. Санхүүгийн зохицуулах хороо сул орон тоог анх орох иргэний нөөцөөс нөхөх талаар хамгийн олон удаа захиалга ирүүлсэн байна. Өмнөх онд Улсын Их Хурлын харьяа байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг зохих журмын дагуу хянан үзэж, ажлын байрны тодорхойлолтод тавигдсан ерөнхий шаардлагыг хангасан 26 иргэнийг нөөцөөс нэр дэвшүүлэн томилох эрх бүхий этгээдэд санал хүргүүлсэн байна.

| № | Байгууллага | Нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалд шалгаруулж авах хүсэлт ирүүлсэн тоо | Тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн тоо | Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүйн улмаас буцаасан иргэдийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхийлөгчийн Тамгын газар | 2 | 2 | - |
| 2 | Улсын Их Хурлын Тамгын газар | 7 | 6 | 2 |
| 3 | Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар | 3 | 3 | - |
| 4 | Санхүүгийн зохицуулах хороо | 4 | 10 | 5 |
| 5 | Хүний эрхийн үндэсний комисс | 4 | 3 | 1 |
| 6 | Сонгуулийн ерөнхий хороо | 2 | 2 | - |
| **НИЙТ** | | **22** | **26** | **7** |

***Яамдуудын захиалга:***

Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх талаар хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлд 10 яам нийтдээ 80 ажлын байрны сул орон тоог нөхөх захиалга ирүүлсэн байна. Ирүүлсэн захиалгыг судлан үзээд тухайн ажлын байрны шаардлагыг хангасан гэж үзсэн 72 иргэнд дүгнэлт гарган, нөөцөөс нэр дэвшүүлэн томилуулж, 8 иргэнийг тухайн Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүй болон бусад шалтгаанаар нэр дэвшүүлэхээс татгалзсан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн хөгжлийн яам хамгийн олон сул орон тоог нөөцөөс сонгон авах замаар нөхөн хангажээ.

| № | Яам | Нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалд шалгаруулж авах хүсэлт ирүүлсэн тоо | Тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн тоо | Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүйн улмаас буцаасан иргэдийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчин аялал жуулчлалын яам | 5 | 7 | 5 |
| 2 | Барилга, хот байгуулалтын яам | 4 | 5 | - |
| 3 | Боловсрол, соёл,шинжлэх ухаан, спортын яам | 1 | 1 | 1 |
| 4 | Зам, тээврийн хөгжлийн яам | 7 | 11 | - |
| 5 | Сангийн яам | 3 | 4 | - |
| 6 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 2 | 2 | 1 |
| 7 | Хууль зүй, дотоод хэргийн яам | 3 | 2 | 1 |
| 8 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 7 | 19 | - |
| 9 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 9 | 18 | - |
| 10 | Эрчим хүчний яам | 3 | 3 | - |
| **НИЙТ** | | **44** | **72** | **8** |

***Агентлагийн захиалга:***

Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх талаар хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлд 19 агентлаг нийт 36 удаагийн албан бичгээр захиалга ирүүлсэн байна. Ирүүлсэн захиалгыг судлан үзээд тухайн ажлын байрны шаардлагыг хангасан гэж үзсэн 61 иргэнд дүгнэлт гарган, нөөцөөс нэр дэвшүүлж, 6 иргэнийг тухайн ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүй болон бусад шалтгаанаар нэр дэвшүүлэхээс татгалзсан байна. Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн туслалцааны төв, Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Алтанбулаг

чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба зэрэг байгууллагууд сул орон тоог нөөцөөс нөхөх хүсэлтийг нийт 6 удаагийн албан бичгээр Зөвлөлд ирүүлснээс ажлын байрны тодорхойлолтод тавигдсан ерөнхий шаардлагыг хангасан гэж үзсэн 12 иргэнийг нэр дэвшүүлжээ.

| № | Байгууллага | Нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалд шалгаруулж авах хүсэлт ирүүлсэн тоо | Тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн тоо | Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүйн улмаас буцаасан иргэдийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Архивын ерөнхий газар | 2 | 2 | |
| 2 | Ашигт малтмал, газрын тосны газар | 2 | 3 | |
| 3 | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар | 1 | 1 | |
| 4 | Гадаадын иргэн харьяатын газар | 10 | 25 | 2 |
| 5 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | 1 | 1 | |
| 6 | Мал эмнэлэг, үржлийн газар | 2 | 2 | |
| 7 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | 1 | | 1 |
| 8 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 2 | 1 | 1 |
| 9 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 1 | 2 | |
| 10 | Стандарт, хэмжил зүйн газар | 5 | 8 | |
| 11 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 4 | 8 | 1 |
| 12 | Үндэсний хөгжлийн газар | 2 | 6 | |
| 13 | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | 4 | 2 | 1 |
| **НИЙТ** | | **36** | **61** | **6** |

Засгийн газрын агентлагуудын хувьд өмнөх онд 19 агентлагийн нийт 91 сул орон тоонд нөөцөөс нэр дэвшүүлсэн бол 2016 онд 13 агентлагийн 61 ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлсэн нь буурсан үзүүлэлтийг харуулж байна. Үүний шалтгаан нь Монгол Улсын

Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд Засгийн газрын бүтэц, бүрэлдхүүнийг шинээр баталсантай холбоотой бөгөөд төрийн байгууллагуудын томилох эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулж, томилгоог хууль тогтоомжид нийцүүлэх нь зүйн хэрэг юм.

| БУСАД БАЙГУУЛЛАГУУД | | | | |
|---|---|---|---|---|
| № | Байгууллага | Нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалд шалгаруулж авах хүсэлт ирүүлсэн тоо | Тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн тоо | Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага хангаагүйн улмаас буцаасан иргэдийн тоо |
| 1 | Шүүхийн ерөнхий зөвлөл | 1 | 1 | - |
| 2 | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба | 1 | 3 | - |
| 3 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба | 1 | 4 | - |
| 4 | Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба | 2 | 3 | - |
| 5 | Хууль зүйн туслалцааны төв | 1 | 1 | - |
| **НИЙТ** | | **6** | **12** | **-** |

***Нутгийн захиргааны байгууллагын захиалга:***

Аймаг, нийслэл дэх салбар зөвлөлд нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн захиалгын дагуу төрийн албанд анх орох иргэний нөөцийн сангаас сонгон шалгаруулж, Салбар зөвлөлөөс дүгнэлт гарган, 275 иргэнийг нэр дэвшүүлжээ.

Үүнээс нийслэл дэх салбар зөвлөл 179, Төрийн албаны зөвлөлийн орон нутаг дахь салбар зөвлөлүүд 96 ажлын байрны сул орон тоог нөөцөөс нэр дэвшүүлэх замаар нөхсөн байна.

Нийслэл дэх салбар зөвлөл 2015 онд 79 ажлын байрны сул орон тоог нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөн хангалт хийсэн бол 2016 онд 179 иргэнийг нөөцөөс нэр дэвшүүлэн томилсон нь харьцангуй өссөн үзүүлэлтийг харуулж байна.

| № | Салбар зөвлөл | Нөөцөөс нэр дэвшүүлсэн иргэдийн тоо |
|---|---|---|
| 1 | Нийслэл дэх салбар зөвлөл | 179 |
| 2 | Орон нутаг дахь салбар зөвлөл | 96 |
| **НИЙТ** | | **275** |

Ажлын байрны сул орон тоонд нөөцөөс нэр дэвшүүлсэн байдлыг нэгтгэн авч үзвэл хот, хөдөө, төв болон нутгийн захиргааны байгууллагууд нийтдээ **446** иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд нөөцөөс нэр дэвшүүлэх замаар томилжээ.

### *B. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний мэдээг нэгтгэх, мэдээллээр хангах талаар:*

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний нэгдсэн тайлан мэдээ гаргах ажлын хүрээнд төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд /Засгийн газрын тохируулагч агентлаг Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, бусад байгууллагуудаас Авлигатай тэмцэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл/-ын тоо бүртгэл, мэдээг нэгтгэн авч улсын хэмжээн дэх бүртгэл мэдээлэлд оруулсан бөгөөд нийтлэг байдлаар Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан, мэдээ, статистикийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар гарган Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 401, 402, 403 тоот албан бичгүүдээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нарт тус тус хүргүүллээ.

Төрийн захиргааны удирдах албан тушаалтны хүйсийн талаарх статистик мэдээг тодорхой албан тушаалуудаар гаргаж бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланд оруулан хэвлэж, зарим сонирхогч этгээдэд дэлгэрэнгүй байдлаар нэгтгэн гаргаж хүргүүлсэн.

Бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлангийн программд нийтлэг гардаг алдааг засч, шаардлагагүй үзүүлэлтүүдийг хасч, мэргэжлийн ангилал болоод зарим сонгодог үзүүлэлтийн өгөгдлүүдэд шинэчлэлт хийсэн.

Программын гарын авлагыг шинэчилж, нийтлэг гардаг алдааны талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Тайлан шивж байгаа албан хаагчдад мэдээлэл өгөх зорилгоор фейсбүүк групп үүсгэсэн. Мэдээлэл оруулах явцад учирч буй асуудал бүрд тухай бүр шийдвэрлэх арга замын талаар заавар өгч, алдаа гарч болзошгүй байвал тэрийг шийдвэрлэх арга замын талаар зурагт зааварчилгаа бэлдэж цахим хуудсанд байршуулж мэдээлэл хүргэж байна.

Төрийн нийт байгууллагын жагсаалтыг Сангийн яамнаас төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч байгууллага нэг бүрээр өмнөх оны бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланд хамрагдсан байгууллагуудтай тулган тайлан гаргах байгууллагын жагсаалтыг шинэчлэн гаргалаа.

Төсөв зардлын улмаас бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан шивж байгаа албан хаагчдад сургалт явуулаагүй боловч програм ашиглах гарын авлага, нийтлэг гарч буй асуудлын талаарх зурагт зааварчилгаа, мэдээлэл оруулах талаар ерөнхий зөвлөмжийг тухай бүр шинэчлэн цахим хуудсанд байршуулан хүний нөөцийн ажилтнуудад програмын хамт цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллалаа.

2017 оны нэгдүгээр улиралд багтаан бүрэлдэхүүн хөдөлгөөний дүн мэдээг төрийн 4271 байгууллагын 188974 албан хаагчдын мэдээллийг цуглуулж, түүнийг нэгтгэсэн. Нэгтгэлд орсон байгууллага, албан хаагчдын мэдээллийн алдааг засварлан төрийн албан хаагчтай холбоотой статистик мэдээллийг гаргасан. Өмнөх оны статистиктай харьцуулан нэмэгдсэн, хасагдсан байдалд дүн шинжилгээ хийсэн.

Тус тайланд төрийн албан хаагчдын байршил, харъяалал, албан тушаалын ангилал, зэрэг дэв, боловсрол, нас, хүйс болон төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөнд орсон шалтгаан зэрэг гол гол **37** үзүүлэлтээр гаргасан.

Мөн тайланд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, УИХ-ын гишүүдээс эрэлт хэрэгцээ ихтэй байдаг зарим үзүүлэлт /тухайлбал, төрийн албан тушаалын төрөл, ангилал тус бүрээрх төрийн албан хаагчдын тоо, аймаг, сумдын төрийн албан хаагчдын тоо г.м./-ийг 2013 оноос эхлэн оруулж байгаа юм. Түүнчлэн "Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль" батлагдсантай холбогдуулан түүний хэрэгжилтийг илэрхийлсэн зарим тоон үзүүлэлтийг нэмж тусгасан болно.

Гол 37 үзүүлэлтээр гаргасан статистик тоймыг хэвлэмэл хэлбэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Ухаалаг төрийн үзэл баримтлалын хүрээнд төрийн албаны хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, сонгон шалгаруулалтын санг бүрдүүлэх, энэ үндсэн дээр төрийн байгууллагын бүтэц, орон тооны оновчтой хувилбар боловсруулах, төрийн албаны санхүүжилтийг захиргааны зардлын бодлого, төлөвлөлтийн үйл явцтай уялдуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хэрэгжиж байгаа **"Боловсролын салбар дахь хүний нөөцийн удирдлагын нэгдсэн систем"-**ийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэхэд Төрийн албаны зөвлөл болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран хувь нэмрээ оруулах, хүч боломжоо нэгтгэн үр дүнд хүргэх чиглэлээр хамтран ажиллахаар **"Санамж бичиг"-**ийг 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан бөгөөд энэхүү санамж бичгийн хүрээнд Ажлын албаны дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн дарга нар Ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, системийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэхэд шаардлагатай зохих түвшний ажил хийгдэж, нэвтрүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвүүлэх талаар Сангийн яаманд хүсэлт тавьж, 2017 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлсэн.

Өмнөх жилүүдэд ашиглаж байсан хүний нөөцтэй холбоотой статистик мэдээг гаргадаг системийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, нэмэлт баяжуулалтыг хийлгүүлэн, бүрэн онлайн бүртгэлийн хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр төрийн албаны хүний нөөцийн мэдээлэл цуглуулах алхам хялбар болж, мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдэж, статистик гаргах үзүүлэлтүүдийг баяжуулах онцгой ач холбогдолтой юм.

# ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЁС ЗҮЙН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Төрийн албаны зөвлөлийн нэг үндсэн чиг үүрэг бол төрийн албан хаагчдын хууль ёсны эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах, мөн ёс зүйн болон бусад зөрчил гаргасан албан хаагчдад зохих ёсны хариуцлага тооцох явдал билээ.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөл хянан шийдвэрлэдэг юм.

Маргааныг хянан шийдвэрлэхдээ Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ыг баримталж ирсэн.

Энэ нь Төрийн албаны тухай хуульд 2002 онд нэмэлт, өөрчлөлт орсноор төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагчийн хооронд төрийн албатай холбогдон гарсан өргөдөл, гомдол маргааныг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу хянан шийдвэрлэж буй үйл явц юм.

***Төрийн албан хаагчдаас Төрийн албаны зөвлөлд хандан 2015 онд нийт 626 өргөдөл, гомдол ирсэн бол 2016 онд 630 өргөдөл, гомдол ирүүлжээ.***

## *3.1 Төрийн албан хаагчийн үр дүнгийн үнэлгээ, урамшуулал ба хариуцлага*

Төрийн албаны тухай хуулийн 35.1.5-д "...төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах" эрхийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлэхээр заасан. Энэ чиг үүргийнхээ дагуу 2015 онд тус зөвлөлөөс төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын хүрээнд тэдний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулах, хариуцлага тооцох журам, дүрмийг цаашид боловсронгуй болгох талаар санал санаачлага гарган ажиллалаа.

Монгол Улсын төрийн албанд хувь хүний гүйцэтгэлийн менежментийг өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж ирсэн байдлыг тоймлон авч үзвэл:

- 1995-2003 онд "Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"
- 2003-2007 онд "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам"

- 2007-2012 онд "Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг / ҮДГ-ний биелэлт/-г үнэлэх журам"
- 2012 онд "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус батлан мөрдүүлж, албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг үнэлж иржээ.

Эндээс үзэхэд өнгөрсөн хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс төрийн албанд хувь хүний гүйцэтгэлийг үнэлэх журамд нэг талаас, хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлт, нөгөө талаас, төв, орон нутгийн байгууллага, албан хаагчдаас гаргасан санал, шүүмжлэлийн дагуу сайжруулах талаар өөрчилж, шинэчилж иржээ.

Ерөнхийд нь авч үзвэл, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ орцод тавих хяналтыг багасгаж, үр дүнд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагыг голлох болсон байна. Мөн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх үйл ажиллагаа нь байгууллага, албан хаагчийн хувьд сэтгэл зүйн болон үйл ажиллагаанд хэвшсэн, тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдолтой зүйл болж ирсэн нь харагдана. Гэхдээ төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох шаардлага амьдралаас урган гарсаар байна.

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын 2014 оны 11 дүгээр тушаалаар "Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ шинэчлэн боловсруулах" ажлын хэсэг байгуулж, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн уялдаа холбоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг энгийн хялбар ойлгомжтой болгох, үнэлгээний бүтцийг сайжруулах, үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, үнэлгээний шатлал тогтоох, гүйцэтгэлийг цалин, хөлс, урамшуулалтай холбох, хөдөлмөрийн сахилгыг хэрхэн сахиж байгааг үнэлэх, хамт олны үнэлгээг авах, өгсөн үүрэг даалгавар, санаачилга, идэвхи, зүтгэлийг үнэлэх, ажлын ачааллыг харгалздаг болох зэрэг асуудлуудыг тусган "Үр дүнгийн гэрээ"-г боловсронгуй болгох үүрэг чиглэл өгсөн.

Ажлын хэсэг гадаад орнуудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, Монгол Улс дах гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, төрийн болон орон нутгийн байгууллагуудад төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байгаа, өмнөх онуудын үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдал зэргийг судлан үзэж журмын төслийг боловсруулсан. Журмын төсөлд дараах гол өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан. Үүнд:

Журамд доорх гол өөрчлөлтүүдийг оруулахаар төслийг боловсрууллаа. Үүнд:

1. Журмыг цомхон, ойлгомжтой болгох, харьцуулахад хялбар болгох үүднээс урьд нь төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагч гэж тус тусад нь журамлаж байсныг нэгтгэн нэг журмаар зохицуулах;
2. Үнэлгээний субьектив байдлыг бууруулах үүднээс тухайн төрийн албан хаагчийн харьяалагдах нэгжийн хамт олонүнэлгээнд оролцдог болох;
3. Гүйцэтгэлийн үнэлгээг урамшуулалтай холбох урьдач нөхцлийг бүрдүүлэх үүднээс байгууллагын нийт албан хаагчдын дунд тухайн үнэлгээг авч болох хязгаарыг тогтоох;

4. Ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь үнэлснээр үнэлгээ илүү бодитой болох, албан хаагчдыг цаг тухайд нь урамшуулах, хариуцлага тооцох боломжтой болгох үүднээс гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэдэг болох;
5. Байгууллагын албан хаагчид харилцан адилгүй ачаалалтай ажиллах, байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд харилцан адилгүйгээр хувь нэмэр оруулах тохиолдолд ачаалалтай ажилласан албан хаагчдыг урамшуулах, байгууллагын зорилтод чиглэн ажиллах соёлыг бүрдүүлэх үүднээс уг үзүүлэлтийг үнэлдэг болох;
6. Үнэлгээг бодитой болгох үүднээс үнэлгээ өгөх үзүүлэлт бүрээр оноо өгөхдөө баримтлах аргачлалыг боловсруулан, аргачлалд тухайн оноог өгөхдөө баримтлах, баримжаа болгох боломжтой байх үүднээс 5 шатлалын оноонд харгалзах үзүүлэлтийг хангасан байх шаардлагын тайлбаруудыг боловсруулав;
7. Илүү бодитой үндэслэлтэй үнэлгээнд суурилсан болгох буюу 3 удаагийн үнэлгээнд үндэслэн авах арга хэмжээний саналыг боловсруулдаг болгох.

Энэхүү журмын төслийн талаар Төрийн албаны зөвлөлийн нийт салбар зөвлөлүүд, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд гэх зэрэг нийт 60 байгууллагаас санал авсан. Үүнээс давхардсан тоогоор 18 байгууллага төслийг бүхэлд нь дэмжсэн ба 1 байгууллага тогтоолын төсөлд 1 санал, 30 байгууллага журмын төсөлд 179 санал, 3 байгууллага дүгнэх хуудасны загварт 7 санал, 6 байгууллага гэрээг дүгнэх аргачлалд 10 санал тус тус ирүүлсэн.

Эдгээр саналыг тусгасан журмын төслийг турших үзэх саналыг Ажлын хэсэг гаргасан. Үүний дагуу Төрийн албаны зөвлөлийн нийт салбар зөвлөлүүд, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд болон аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 2-оос доошгүй агентлаг, 2-оос доошгүй сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрыг хамруулан турших ажлыг зохион байгуулан туршилтын ажлын явцад илэрсэн гэрээ байгуулах болон дүгнэхэд тулгарч буй бэрхшээл, анхаарах асуудлууд болон албан хаагчдаас гарсан санал зэргийг тусгасан туршилтын тайланг хүлээн авах ажлыг зохион байгуулсан.

Төрийн албан хаагчдын 2016 оны үйл ажиллагааны үр дүнг одоо мөрдөж буй "Үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу үнэлж дүгнэсэн болно. Төрийн байгууллагууд албан хаагчдынхаа үйл ажиллагааг хэрхэн үнэлж, дүгнэсэн байдлыг авч үзвэл:

Ажлын гүйцэтгэлийг жилийн эцсээр үнэлсэн нийт төрийн албан хаагчийн үнэлгээний байдал:

| Үнэлгээ | ТАХ-ын тоо | Хувь |
|---|---|---|
| **"A" буюу Маш сайн** | 25851 | 37.65% |
| **"B" буюу Сайн** | 34302 | 49.96% |
| **"C" буюу Хангалттай** | 7811 | 11.38% |
| **"D" буюу Дутагдалтай** | 583 | 0.85% |
| **"E" буюу Огт хангалтгүй** | 107 | 0.16% |
| **Нийт** | **68654** | **100.00%** |

*Жич: 2016.12.31-ий өдрийн байдлаар Зөвхөн үр дүнгийн гэрээний үнэлгээ гэсэн талбарыг бөглөсөн албан хаагчдын мэдээлэл*

Эндээс үзэхэд бүртгэл судалгаанд хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдын 87.61 хувь нь "Маш сайн буюу Сайн" үнэлгээ авсан байх бөгөөд тэдний 42.97 хувь нь 90-ээс дээш оноо авч "А" буюу "Маш сайн" гэсэн үнэлгээтэй дүгнэгджээ.

Энэ нь нэг талаас албан хаагчид гэрээгээр хүлээсэн ажил үүргээ сайн гүйцэтгэдэг гэсэн үзүүлэлт боловч нөгөө талаасаа үнэлгээ хэр бодитой вэ?, гэрээний үзүүлэлтүүдэд үнэхээр гол чухал ажил үйлчилгээгээ тусгаж чадсан эсэх асуудлыг нухацтай авч үзэж, үр дүнгийн гэрээ дүгнэх журмаа илүү боловсронгуй, бодитой болгох шаардлага байгааг харуулж байгаа юм.

Дутагдалтай буюу хангалтгүй үнэлэгдсэн нь ердөө 1.01 хувь байгаа нь ч бас анхаарал татаж байна. Тэгвэл энэ үзүүлэлт төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд ямар байгаа нь доох хүснэгтээс харагдаж байна.

**Төрийн үйлчилгээний албан хаагчид**

| Үнэлгээ | ТАХ-ын тоо | Хувь |
|---|---|---|
| "А" буюу Маш сайн | 18132 | 35.52% |
| "В" буюу Сайн | 26441 | 51.80% |
| "С" буюу Хангалттай | 6033 | 11.82% |
| "D" буюу Дутагдалтай | 369 | 0.72% |
| "Е" буюу Огт хангалтгүй | 73 | 0.14% |
| **Нийт** | **51048** | **100%** |

Эндээс харахад "Маш сайн" буюу "А" үнэлгээний хувь захиргааны албан хаагчдынхаас даруй 10 гаруй хувиар бага байгаа нь харьцангүй бодитой үнэлгээ мэт харагдана.




Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээг үндэслэн авах арга хэмжээ, тухайлбал: шагнаж урамшуулах, хариуцлага тооцох зэрэг асуудлын хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ.

Үр дүнгийн гэрээнд тулгуурлан төрийн албан хаагчдыг урамшуулах, дэмжих олон хэлбэр байдаг. Үүнд:

- Албан тушаал дэвшүүлэх;
- Албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэх;
- Цалин нэмэх буюу цалингийн шатлал ахиулах;
- Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох;
- Байгууллагын салбарын болон бусад шагналд тодорхойлох;
- Төрийн одон, медалиар шагнуулахаар тодорхойлох гэх мэт.

Эдгээрээс төрийн албан хаагчийн зэрэг дэв олгох асуудал нь Улсын Их Хурлаас баталсан журмыг үндэслэж явагддаг. Энэ журамд зааснаар туслах, дэс, ахлах түшмэлийн зэрэг дэвийг Монгол Улсын Сайд, Улсын Их хурлын болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын дарга, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог газруудын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар тус тус олгоно гэж заасан.

Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг Монгол Улсын сайд, Тэргүүн түшмэлийн зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч олгохоор журамласан байдаг. Ингэхдээ тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг олгоход Төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлтийг авсан байх журамтай.

Энэ журмын дагуу Төрийн албаны зөвлөл тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг судлан дүгнэлт гаргаж, Засгийн газарт өргөн мэдүүлж ирлээ.

**Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв олгосон байдал.** Монгол Улсын Их Хурлын "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Төрийн албаны зөвлөлд 2016 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны /давхардсан тоогоор/ **33** байгууллагаас нийт **75** албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн болон тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах тухай санал ирүүлсэн. Үүний **15** нь тэргүүн түшмэлийн, **60** нь эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах санал байлаа.

Тодорхойлолт ирүүлсэн байгууллагын тоо өмнөх оноос 4-өөр, Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр авах, зэргийг нь ахиулахаар тодорхойлогдсон албан хаагчдын тоо 47-оор тус тус цөөрсөн байна.

Салбар зөвлөлөөс ирүүлсэн дээрх саналыг "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох журам"-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны 3 гишүүний бүрэлдэхүүнтэй "Ажлын хэсэг" ажиллаж, зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн баримт бичгийг нягтлан шалгаж, хүн нэг бүрчлэн судалж үзсэний үндсэн дээр шаардлага хангасан гэж үзсэн **12** албан хаагчид төрийн захиргааны Тэргүүн түшмэлийн, **38** албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах санал дүгнэлтийг гаргаж, танилцуулга, төсөл боловсруулан Төрийн албаны зөвлөлийн **5** удаагийн хуралдаан (2016-03-25, 2016-04-21, 2016-06-09, 2016-07-01, 2016-11-03-ны өдрийн)-аар тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Монгол Улсын Засгийн газарт уламжилсан болно. Үүнд:

| № | Зэрэг дэв олгуулах санал уламжилсан тухай Төрийн албаны зөвлөлийн албан тоотын огноо, дугаар | Зэрэг дэв олгуулах албан хаагчдын тоо | |
|---|---|---|---|
| | | Тэргүүн түшмэл | Эрхэлсэн түшмэл |
| 1 | 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн №289 тоот | 1 | 12 |
| 2 | 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №434 тоот | 5 | 1 |
| 3 | 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №639 тоот | 1 | 3 |
| 4 | 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн №744 тоот | 2 | 21 |
| 5 | 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №1144 тоот | 3 | 1 |
| **Нийт** | | **12** | **38** |

Засгийн газар төрийн захиргааны албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох тухай Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг хэлэлцээд дэмжсэн байна. Тиймээс Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 57 дугаар захирамжаар 35 албан хаагч, 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 97 дугаар захирамжаар 3 албан хаагч, нийтдээ төрийн захиргааны 38 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох шийдвэр гаргажээ. Үүнийг зэрэг дэвээр нь ялган авч үзвэл 3 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн Тэргүүн зэрэг, 2 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн Дэд зэрэг, 8 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн Гутгаар зэрэг, 25 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн Дөтгөөр зэрэг тус тус олгосон байна.

Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв авсан 38 албан хаагчийн тоог сүүлийн 4 жилийн байдлаар харьцуулан авч үзвэл:

| ЗЭРЭГ ДЭВ | | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Тэргүүн зэрэг | Эрхэлсэн түшмэл | 1 | 2 | 6 | 3 |
| Дэд зэрэг | Эрхэлсэн түшмэл | 2 | 6 | 5 | 2 |
| Гутгаар зэрэг | Эрхэлсэн түшмэл | 9 | 12 | 13 | 8 |
| Дөтгөөр зэрэг | Эрхэлсэн түшмэл | 12 | 34 | 43 | 25 |
| **Нийт** | | **24** | **54** | **67** | **38** |

2016 онд эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгосон албан хаагчдын гуравны нэг буюу 66 орчим хувь нь эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг анх удаа хүртээж байгаа бол 13 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан байна.

Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн байдлыг авч үзвэл:

| Зэрэг дэв | Түшмэлийн ангилал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тэргүүн түшмэл | Эрхэлсэн түшмэл | Ахлах түшмэл | Дэс түшмэл | Туслах түшмэл | Бүгд |
| **Тэргүүн** | 24 | 68 | 220 | 742 | 49 | 1103 |
| **Дэд** | 12 | 42 | 149 | 517 | 53 | 773 |
| **Гутгаар** | 12 | 45 | 216 | 892 | 133 | 1298 |
| **Дөтгөөр** | 24 | 75 | 310 | 1397 | 255 | 2061 |
| **Зэрэг дэвтэй** | 72 | 230 | 895 | 3548 | 490 | 5235 |
| **Зэрэг дэвгүй** | 58 | 12 | 1015 | 9503 | 3137 | 13725 |
| **Нийт** | **130** | **242** | **1910** | **13051** | **3627** | **18960** |

Төрийн захиргааны албан хаагчийн Тэргүүн түшмэлийн зэрэг дэвийг....

**"Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнасан байдал.** Төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвар гарган, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт үзүүлж үйл ажиллагааны үнэлгээгээр сайн үнэлэгдсэн, төрийн байгууллагын зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан ба төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд шинэлэг арга ажиллагааг нэвтрүүлсэн, ёс зүй, манлайллын хувьд үлгэр жишээ ажиллаж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан албан хаагчдыг **"Төрийн албаны тэргүүний ажилтан"** цол тэмдэгээр шагнах болсон нь төрийн албан хаагчдын идэвх зүтгэлийг өрнүүлэх, төрийн албыг мэргэшсэн тогтвортой байлгах, төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнгийн үнэлгээг урамшуулах чухал алхам болсон юм.

"Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-д зааснаар дараах болзол, шаардлагыг хангасан төрийн албан хаагчид "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдэгийг олгохоор зохицуулсан байдаг. Үүнд:

- Төрийн албанд 18-аас дээш жил ажилласан,
- Ажил мэргэжлээрээ тухайн салбарын тэргүүний ажилтны болзол хангасан,
- Мэргэжлийн өндөр ур чадвар гарган эрхэлсэн ажилдаа өндөр амжилт үзүүлсэн,
- Сүүлийн 5 жилд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "А", "В" үнэлэгдсэн байна;

Төрийн албаны зөвлөлд энэхүү шагналаар шагнуулахаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг" судлан нягталж, шагнуулахаар тодорхойлогдож ирүүлсэн хүмүүсийн баримт материалыг дээрх журамд заасан үзүүлэлт бүрээр шалган, тодорхойлогдож ирүүлсэн хүн тус бүрт дүгнэлт гаргадаг. Зөвлөл Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг жил бүр шинэчлэн тогтооно.

Төрийн албаны зөвлөлд "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулахаар 2016 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 81 /давхардсан тоогоор/ байгууллагаас нийт 235 албан хаагчийг тодорхойлон ирүүлжээ. Ирүүлсэн материалыг дээрх Ажлын хэсэг журмын дагуу нэг бүрчлэн судлан үзээд, шаардлага хангасан гэж үзсэн нийт **197** албан хаагчийг шагнуулах тухай дүгнэлт гаргасан байна. Ажлын хэсгийн боловсруулсан танилцуулага, дүгнэлт, тогтоолын төслийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн.

Энэ асуудлаар өнгөрсөн онд нийтдээ 7 удаа хуралдаж шийдвэр гаргажээ. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

| № | Шагнах шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаар | Шагнагдсан албан хаагчдын тоо |
|---|---|---|
| 1 | Төрийн албаны зөвлөлийн 2015-02-05-ны өдрийн 11 дүгээр тогтоол | 16 |
| 2 | Төрийн албаны зөвлөлийн 2016-03-25-ны өдрийн 33 дугаар тогтоол | 11 |

| | | |
|---|---|---|
| 3 | Төрийн албаны зөвлөлийн 2016-06-10-ны өдрийн 61 дүгээр тогтоол | 51 |
| 4 | Төрийн албаны зөвлөлийн 2016-07-01-ний өдрийн 74 дүгээр тогтоол | 74 |
| 5 | Төрийн албаны зөвлөлийн 2016-11-24-ний өдрийн 191, 192 дугаар тогтоол | 27 |
| 6 | Төрийн албаны зөвлөлийн 2016-12-15-ны өдрийн 241 дүгээр тогтоол | 10 |
| 7 | Төрийн албаны зөвлөлийн 2016-12-23-ны өдрийн 243 дугаар тогтоол | 8 |
| | **Нийт** | **197** |

"Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдэгээр шагнагдсан байдлыг сүүлийн 5 жилээр харьцуулбал:

| Он | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| **Шагналд тодорхойлогдсон албан хаагчийн тоо** | 247 | 204 | 249 | 241 | 235 |
| **Шагнагдсан албан хаагчийн тоо** | 174 | 120 | 168 | 157 | 197 |




Эндээс үзэхэд шагнуулахаар тодорхойлж ирүүлсэн хүний тоо шагнагдсан албан хаагчдын тоо зөрүүтэй байгаа нь харагдана. Энэ бол шагналын болзол, шаардлага хангаагүй хүнийг тодорхойлж ирүүлэх, материал бүрдүүлэлт дутуу зэргээс хамаарч шагнагдаагүй үлдсэн хүмүүсийн тоог харуулж байгаа юм.

Тэгвэл 2016 оны хувьд Салбар зөвлөлүүдээс тодорхойлж ирүүлсэн албан хаагчдын 84 орчим хувь нь журамд заасан болзол шаардлагыг бүрэн хангасан гэсэн үг юм. Энэ үзүүлэлт өмнөх жилүүдийнхээс нэмэгдсэн нь журамд заасан болзол шаардлагыг хангасан ажилтнуудыг нэр дэвшүүлэх, баримт материалын бүрдүүлэлт, нотолгоог хангах талаар өгсөн Төрийн албаны зөвлөлийн санал, зөвлөмжийг салбар зөвлөлүүд болон төрийн байгууллагууд хэрэгжүүлж ажиллаж буйн нэг илрэл юм.

Энэ онд нийт шагнагдсан хүмүүсийн төрийн албанд ажилласан жил хамгийн бага нь 21 жил ажилласан, нийт шагнагдсан хүмүүсийн дийлэнх нь 26 ба түүнээс дээш 40 жил хүртэл ажилласан. Насны хувьд хамгийн бага нь 41 настай ба хамгийн ахмад нь 67 хүртэлх насны хүмүүс байлаа.

Төрийн албан хаагчдын хөдөлмөр, зүтгэлийг шударга, бодитой үнэлж дүгнэх, журамд заасан болзол шаардлагыг ягштал мөрдөж ажиллахыг салбар зөвлөл болон төрийн байгууллагын холбогдох албан тушаалтанд санал, зөвлөгөө өгч ажиллалаа.

## *3.2 Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт*

Төрийн байгууллагын соёл болон төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх нь тус зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамааралтай үүрэг, зорилтын нэг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2016 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллалаа.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороонуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн үзвэл 2016 онд нийт **193** ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс:

- Төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой **19**,
- Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчтай холбоотой **174** ёс зүйн зөрчил бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад **5.4** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр нэгтгэн гаргав. Үүнд:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ 2016 ОНЫ МЭДЭЭ

| 2016 он | ЁС зүйн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авсан үндэслэл | | | | | Зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох | | Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Журмын 1.2 | | Журмын 2.2.5 | | | | | Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн эсэх | | Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр | | | |
| | Гомдлоор | Мэдээллээр | Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр | Ёс зүйн хороо өөрийн санаачлагаар | Байгууллагын удирдлагын шийдвэрээр | Анх | Давтан | Зөвшөөрсөн | Зөвшөөрөөгүй | ТАТХ-ын 26.1.1 | ТАТХ-ын 26.1.2 | ТАТХ-ын 26.1.3 | Сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн |
| Төрийн захиргааны удирдах албан хаагч | 4 | 2 | | 1 | 12 | 18 | 1 | 15 | 4 | 6 | 7 | 3 | 3 |
| | Ёс зүйн зөрчил-19 | | | | | | | | | | | | |
| Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагч | 92 | 3 | | 2 | 77 | 148 | 26 | 143 | 31 | 58 | 54 | 10 | 52 |
| | Ёс зүйн зөрчил-174 | | | | | | | | | | | | |
| НИЙТ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ | 96 | 5 | | 3 | 89 | 166 | 27 | 158 | 35 | 64 | 61 | 13 | 55 |
| | Нийт ёс зүйн зөрчил-193 | | | | | | | | | | | | |

Дээрх хүснэгтээс харахад төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэн ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол **96** байхад байгууллагын удирдлагын санаачлага, шийдвэрээр ёс зүйн зөрчлийг авч хэлэлцсэн тохиолдол **89** байна.

Харин ёс зүйн хороод хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтат мэдээлэл болон өөрийн санаачлагаар төрийн албан хаагчийн ёс зүйн үйлдлийг авч хэлэлцсэн тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь ёс зүйн хороод өөрийн санаачлагатай, идэвхитэй ажиллах байдал сулавтар байгааг харуулж байна.

Ёс зүйн зөрчлийг анх удаа гаргасан **166** албан хаагч байгаа бол давтан гаргасан **27** албан хаагч байгаагаас Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн **158**, хүлээн зөвшөөрөөгүй **35** албан хаагч байна.

Ёс зүйн хороодын дээрх шийдвэрээр төрийн албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийг төрлөөр авч үзвэл:

- 64 албан хаагчид-сануулах /ТАТХ-ийн 26.1.1/,
- 61 албан хаагчид-албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах /ТАТХ-ийн 26.1.2/,
- 13 албан хаагчид-төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах / ТАТХ-ийн 26.1.3/ гэсэн сахилгын шийтгэлийг тус тус ногдуулжээ.

Харин төрийн захиргааны албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан гэх мэдээллийг Ёс зүйн хороодоос хянан шалгаж, **55** албан хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэх шаардлаггүй буюу ёс зүйн зөрчил гаргасан гэх өргөдөл, гомдол, мэдээлэл үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Эндээс харахад материаллаг /цалин бууруулах/ болон ёс зүйн /сануулах/ шийтгэл зонхилж байгаа нь харагдана. Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл нийт сахилгын шийтгэлийн 9.5 хувийг эзэлж байна.

Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай сүүлийн 5 жилийн байдлыг харьцуулан үзэхэд өнгөрөгч 2016 онд бүртгэгдэж ёс зүйн хороодоор хэлэлцэгдсэн зөрчлийн тоо өмнөх жилийн буюу 2015 оны дүнгээс **19** буюу **8.9** хувиар буурсан байна.



Ийнхүү ёс зүйн зөрчил буурсан нь Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн хороодын гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгч, ажлыг нь дүгнэж ажилласан, төрийн албан хаагчдын дунд ёс зүйн сургалтыг тухай бүр зохиож байгаагийн дунд зарим газарт хороодын үйл ажиллагаа тогтмолжиж, идэвхжсэнтэй холбоотой байж болох юм. Зарим байгууллагын ёс зүйн хороодын үйл ажиллагаа тогтмолжихийн хэрээр иргэд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар хаана, хэрхэн, яаж хандах байдалд өөрчлөлт гарч байна. Төрийн албан хаагчид ч өөртэй нь холбоотой гарсан гомдол, шүүмжлэлийг ёс зүйн хороогоор хэлэлцүүлж, зөв буруугаа хагалуулах, буруу бол зохих шийтгэлээ хүлээн зөвшөөрөх, буруугүй бол нэр төрөө сэргээлгэх гэсэн зөв голдирол руу явж байгаа эрүүл үзэгдэл энэ “бууралтын”-ийн цаана бас байгаа гэж үзэлтэй.

Гэвч нөгөө талдаа албан хаагчдын ёс зүйгүй үйлдэлд хайхрамжгүй, тоомжиргүй хандах, иргэдийн гомдол, мэдээлэлд хойрго хандаж, зохих журмын дагуу ёс зүйн зөрчлийг авч хэлэлцэхгүй, хариуцлага тооцохгүй байдал үргэлжилсээр байгаад цаашид ч дүгнэлт хийж ажиллах шаардлага байна.

Ер нь зарим төрийн албан хаагчдийн ёс зүй доогуур байгаа бодит үнэнг үгүйсгэх аргагүй. Сүүлийн жилүүдэд төрийн албанд багагүй хөдөлгөөн орж, удирдах болон гүйцэтгэх албан тушаалд төрийн албаны наад захын ёс зүйн мэдрэмжгүй, туршлагагүй хүмүүс томилогдох, бүр заримдаа сонгон шалгаруулалтгүй, хууль бус замаар орж ирсэн явдал нь төрийн албаны ёс зүй, соёлд бас сүүдрээ тусгасан. Тэд иргэдтэй харилцах харилцаандаа алдаа гаргадаг, туршлага дутмаг нь төрийн албан хаагчийг ёс зүйгүй харагдуулдаг. Тэд бас байгууллагын дотоод соёлыг эвдэж, дур зоргын, албан бус үйлдэл гаргах нь байдаг. Энэ бүх байдал нь бүхэлдээ төрийн алба, төрийн байгууллага, жирийн төрийн албан хаагчдын нэр төрд халтай.

2016 оны 07 дугаар сараас төрийн захиргааны байгууллагуудын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж тухайн байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороодыг шинээр болон шинэчлэн байгуулах шаардлага гарч байгаа тул Ёс зүйн хороодыг байгуулах, үйл ажиллагааг идэвхижүүлэх, сургалт зөвлөгөөг сайтар өгөхөд анхаарч ёс зүйн хэсэгчилсэн сургалтуудыг Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлүүдээр дамжуулан зохион байгуулах талаар цаашид ч онцгойлон анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

## *3.3 Төрийн албан хаагчийн эрхийн хамгаалалт, гомдол маргаан*

2016 онд Төрийн албаны зөвлөлд нийт **630** өргөдөл, гомдол ирүүлснийг төрөлжүүлж, бүлэглэж авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

| д/д | Гомдол гаргасан шалтгаан | Тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн | 187 | 29.7 |
| 2 | Ажлаас халагдсан асуудлаар | 144 | 22.8 |
| 3 | Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт дүгнэлт, нөөц, томилгоотой холбоотой | 72 | 11.9 |
| 4 | Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн сонгон шалгаруулалт, дүгнэлт, нөөц, томилгоотой холбоотой | 62 | 9.8 |
| 5 | ТАХ-ийн хууль бус үйл ажиллагаа, ёс зүйтэй холбоотой | 31 | 4.9 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Албан тушаал бууруулсан тухай | 28 | 4.4 |
| 7 | Тэтгэвэр тэтгэмж, цалин хөлстэй холбоотой | 27 | 4.3 |
| 8 | Дахин өргөдөл гаргасан | 18 | 2.8 |
| 9 | Сахилгын шийтгэл ногдуулсан | 12 | 1.9 |
| 10 | Төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбоотой | 10 | 1.6 |
| 11 | Албан тушаалд томилохгүй байгаа тухай | 11 | 1.7 |
| 12 | Сэлгэн ажиллуулахтай холбоотой | 8 | 1.3 |
| 13 | Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа тухай | 6 | 0.9 |
| 14 | Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой | 4 | 0.6 |
| 15 | Бусад | 10 | 1.4 |
| | **Нийт** | **630** | **100** |

Эдгээр өргөдөл, гомдлыг судлан үзэж, холбогдох байгууллага, албан тушаалтан, Салбар зөвлөлд харьяаллын дагуу өгч шийдвэрлүүлснээс гадна Төрийн албаны зөвлөл, түүний ажлын алба хариу өгч шийдвэрлэсэн байна.

Тайлант онд төрийн албаны төв байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын тоо өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна. Гомдол гаргасан шалтгаанаар нь ангилан авч үзвэл ажлаас үндэслэлгүй халагдсан болон бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн гэсэн өргөдөл, гомдол дангаараа нийт гомдлын 52.6 хувийг эзэлж байгаа юм. Энэ төрлийн гомдол урд оныхоос 15 хувиар өссөн нь анхаарал татаж байна. Учир шалтгааныг судлан үзвэл энэ төрлийн өргөдөл, гомдол нэмэгдсэн нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн болон яам, агентлагийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотой байна.




Тухайлбал, тайлант онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн сонгуулийн үр дүнд шинэчлэгдэн батлагдсанаар нэлээд яам, агентлагийн удирдлага шинээр томилогдож, бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбоотойгоор төрийн албан хаагчдын хөдөлгөөн нэлээд гарсан. Мөн хэмнэлтийн горимд шилжиж, Засгийн газар, яам, агентлагийн албан хаагчдын тоог 10 хүртэл хувиар цомхотгох шийдвэр гарснаас олон орон тоо цомхотгогдож төдий хэмжээний албан хаагчид чөлөөлөгдсөн юм. Үүнтэй холбоотойгоор гарсан захиргааны шийдвэрт зарим албан хаагчид гомдол гаргажээ.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд ийнхүү төсвийн жилийн дотор ойр ойрхон өөрчлөлт хийсэн нь төрийн албан хаагчдын эрх ашиг, зөрчигдөхөд хүргэсэн төдийгүй бүхэлдээ Монгол Улсын төрийн алба тогтвортой, залгамж чанартай, үр нөлөөтэй байх зарчим алдагдахад нөлөөлсөн байна.

Үүнээс үзэхэд өнгөрсөн жил Улсын Их Хуралд танилцуулсан Төрийн албаны зөвлөлийн тайланд дурдсан дүгнэлтээс Засгийн газар сургамж авсангүй гэж хэлж болохоор байна.

Төрийн албан хаагчдын зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр зөвлөл анхаарч ажиллалаа. Тухайлбал, бүтцийн өөрчлөлтийн үед төрийн мэргэшсэн албан хаагчдыг хууль бусаар халахгүй байх, хүний нөөцийн томилгоонд хууль, тогтоомжыг мөрдөж ажиллахыг анхааруулсан сануулга, зөвлөмжийг ЗГХЭГ, шинээр томилогдсон яамдын сайд нарт албан тоотоор хүргүүлж, хууль тогтоомжийн лавлагаа гарган өгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэх саналаа илэрхийлж ажилласан.

**Маргаан хянан шийдвэрлэсэн талаар:** Тайлант онд эрх зүйн үндэс, бодлогын баримт бичгийн хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.3.2, 4.8.6, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”, Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийн баримт бичгийн “төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэх” гэсэн заалтуудыг баримтлан нийт **3** гомдол маргаанд Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар маргаан хянан шийдвэрлэх комисс томилон хянан шийдвэрлэв. Маргаан хянан шийдвэрлэх комисс гомдол маргааныг нарийвчлан хянан үзээд эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй буюу гомдол гаргагч талынх нь үндэслэлтэй гэж шийдвэрлэснийг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд комиссын шийдвэрийг дэмжсэн **3** удаагийн тогтоолыг гаргасан байна. Дээрх гомдол, маргааныг төрлөөр нь авч үзвэл:

- Албан тушаал бууруулсан 2
- Албан тушаалаас чөлөөлөгдсөн 1

| Он | Нийт өргөдөл гомдлын тоо | | ТАТХ-ийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянан шийдвэрлэсэн маргаан | Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн | Эрх бүхий албан тушаалтын шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн |
|---|---|---|---|---|---|
| 2012 | 234 | МАРГААН | 16 | 4 | 12 |
| 2013 | 395 | | 5 | - | 5 |
| 2014 | 512 | | 14 | - | 14 |
| 2015 | 626 | | 8 | - | 8 |
| **2016** | **630** | | **3** | **-** | **3** |

Төрийн албаны зөвлөлөөс маргаан хянан шийдвэрлэсэн тухай дээрх 3 шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан шууд биелүүлсэн байна.

Эндээс үзэхэд Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг хүлээн авч, эрх зүйн алдаатай захиргааны шийдвэрээ залруулан засч, иргэд, төрийн албан хаагчдын зөрчигдсөн эрхийг сэргээсэн шийдвэр бүрэн биелсэн байна.

Маргаан хянан шийдвэрлэлтийн байдалд хийсэн дүгнэлтэд тулгуурлан Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчиж байгаа нийтлэг зөрчлийг арилгах, албан тушаалтнуудыг төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдуулан гаргах шийдвэрээ хуулийн дагуу гаргах, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдлаа.

# ДҮГНЭЛТ САНАЛ

## *Төрийн албаны тухай хууль, эрх зүйн бодлого, стандартын удирдлагыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:*

Төрийн албаны тухай хууль анх 1995 онд батлагдаж хэрэгжиж эхэлснээс хойш 20 гаруй жил болжээ. Энэ хугацаанд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орж шинэчлэгдэж ирсэн ч төрийн албаны өнөөгийн харилцааг зохицуулах шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байна.

Иймд Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулан шинэчлэх нь нийгмийн захиалга төдийгүй бүр тулгамдсан хэрэгцээ шаардлага болоод байгааг өнгөрсөн онуудын үйл явц маш тодорхой харууллаа. Ингэхдээ энэ асуудалд ул суурьтай, нухацтай хандаж, Үндсэн хуулийн өөрчлөлттэй уялдуулах замаар улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой, нэр хүндтэй төрийн албаны тогтолцоог бүрэлдүүлэх, түүнийг хамгаалах чадамж бүхий Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллага бий болгох зарчмын шинэ үзэл баримтлалд суурилсан хууль эрх зүйн шинэчлэл хийх нь тулгамдсан зорилт болж байна.

Монгол Улсын төрийн тогтолцооны асуудлаар улс орон даяар явуулсан санал асуулгын судалгааны “Төрийн албаны тогтвортой байдлыг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж та үзэж байна” гэсэн асуултанд хариулсан 2246 хүний 54 хувь нь төрийн албаны эрх зүйн хамгаалалтыг Үндсэн хуульд тусгах нь зүйтэй гэж үзсэн байв.

Төрийн албыг аль болох улс төрөөс ангид байлгах, үүний тулд төрийн албан хаагчдыг гагцхүү мэргэжлийн ур чадвар, ёс зүйд үндэслэн шатлан дэвшүүлэх зарчимд суурилсан томилгоо хийх, сонгууль бүрийн дараа хавтгайруулсан халаа сэлгээ, хөдөлгөөн хийх байдлыг эцэс болгох нь улс, нийгмийн хөгжилд тустай гэж иргэд үзэж байна. Дээрх судалгаанд оролцсон иргэдийн 28,2 хувь нь төрийн албаны томилгоонд улс төрийн намуудын оролцоог хуулиар хориглох нь зүйтэй гэсэн саналаа илэрхийлжээ.

Үндсэн хуульд тодорхойлсон хараат бус, бие даасан байгууллага бий болсноор л Монгол Улсын хэмжээнд төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг жигд хангуулах, улс төрөөс ангид мэргэшсэн, тогтвортой мерит тогтолцоо бүхий төрийн албыг хамгаалах, бэхжүүлэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх боломжтой гэдэгт эрдэмтэд судлаачид, иргэд олон нийт мөн санаа бодол нэгдэж байна.

Энэхүү нийгмийн шаардлагын үүднээс Төрийн албаны тухай хуулийг шинэчлэхэд дараах үндсэн зарчим, бодлогыг тусган баталгаажуулж өгөх нь зайлшгүй чухал гэж үзэж байна. Үүнд:

1. **Төрийн албаны эрх зүйн Үндсэн хуулийн хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.** Монгол Улсын Үндсэн хуульд төрийн албаны талаар бага хөндсөн. Төрийн алба мэргэшсэн, тогтвортой, мерит тогтолцоотой байх зарчим Үндсэн хуульд тодорхой тусгагдаагүй. Төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагын статус, эрх мэдлийн талаар тусгасан заалт байхгүй. Төрийн албаны тухай хуульд дээрх асуудлууд тодорхой хэмжээгээр тусгагдаж зохицуулагдсан байдаг боловч Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт буюу дархлаа сул байгаа тул Төрийн албаны

тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй явж ирсэн байна. Иймд Монгол Улсын төрийн албаны талаарх Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох асуудал нь төрийн албаны хууль, эрх зүйн энэ удаагийн шинэчлэлийн гол зорилт болоод байна.

2. **Төрийн албаны томилгоог мерит зарчимд тулгуурласан, шатлан дэвшүүлэх карьерийн системээр сонгон шалгаруулж томилдог арга, механизмыг хуульчлах.** Төрийн албан тушаалын шатлал бүрд зайлшгүй ажиллах хугацааг тодорхой болгож хугацааны хяналтад оруулах шаардлагатай байгаа юм. Энэ арга, механизм нь гадаадын олон орны төрийн албаны томилгоонд хэрэглэдэг сонгомол аргуудын нэг юм.

3. **Бүтцийн өөрчлөлт нэрийдлээр төрийн албан хаагчдыг халж, чөлөөлдөг байдлыг зогсоох шаардлагатай байна.** Засгийн газрын бүтэц, түүнийг дагаж төрийн захиргааны байгууллагуудын нэгжийн бүтцийг өөрчилдөг. Бүтцийн өөрчлөлтийг төрийн албан хаагчийг ажлаас халж, чөлөөлдөг хэрэгсэл болгосоор олон жилийн нүүр үзэж байна. Байгууллагын болон түүний бүтцийн нэгжийн мөн тодорхой ажлын байрны үндсэн чиг үүрэг өөрчлөгдөөгүй байхад төрийн албан хаагчдыг өөрчлөх, ажлаас халахыг хуулиар хорих шаардлагатай.

4. **Улс төрөөс хараат бус байх нөхцлийг зөв зохистой бүрдүүлэх хэрэгцээ байна.** Монгол Улсын хэмжээнд өнөөдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу Улс төрийн албан тушаалтан нар 2016 онд нийт төрийн албаны 155 албан тушаалд 4841 төрийн албан хаагчийг томилж, чөлөөлөх шийдвэр гаргаж байгаа. Тухайлбал, төрийн сайд нар 115 албан тушаалд нийт 361 төрийн албан хаагчийг, аймаг нийслэлийн Засаг дарга нар 7 албан тушаалд 670 албан хаагчийг томилж, чөлөөлж байна. Үүнээс гадна аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяа нутаг дэвсгэрт байгаа бүх сургууль, цэцэрлэгийн эрхлэгчийг томилж, чөлөөлж байгаа. Нийт 1600 орчим төрийн албан хаагчид байна. Мөн сум, дүүргийн Засаг дарга нар 6 албан тушаалд 3141 орчим албан хаагчийг томилж, чөлөөлж байна. Төрийн албан хаагчдыг, тэр тусмаа төрийн захиргааны албан хаагчдыг улс төрийн албан тушаалтан томилж, чөлөөлөх нь улс төрийн оролцооны нэг хэлбэр гэж үздэг. Салбар хуулиудаар зохицуулсан энэхүү асуудлыг нэгдсэн нэг хуулиар зохицуулагддаг тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй.

5. **Сул орон тоо нөхөх хугацааг хуульчлах шаардлагатай.** Төрийн албанд сул орон тоо байнга гарч байдаг. Энэ бол зүй тогтол. Гэвч сул орон тоог богино хугацаанд нөхөөгүй тохиолдолд ихээхэн зөрчил үүсч, ажил цалгардаж, олон сөрөг үр дагавар гардаг. Судалгаа болон практикаас үзэхэд төрийн албанд гарсан сул орон тоог дунджаар 2 сард багтаан нөхөх боломж бий. Сул орон тоог нөхөх хугацааг тодорхой болгосноор түр орлон гүйцэтгэгч нэртэй эрх зүйн чадамжгүй хүмүүс элдэв шалтаг, шалтгаан тоочиж урт хугацаагаар орон тоо бөглөж суудаг байдлыг арилгана.

6. **Төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай. байна.** төрийн албанд томилогдсон хүн ёс зүйн болон сахилгын зөрчил гаргадаг асуудал арилахгүй байна. Төрийн албаны хүнд суртал, хариуцлагагүй байдал иргэд, олон нийтийг

бухимдуулсаар байна. Түүгээр барахгүй төрийн албан хаагчид авлига, хээл хахуульд холбогдох тохиолдол зогсохгүй байна. зөвхөн 2016 онд 7 төрийн албан хаагч авлига, хээл хахуулийн хэргээр шүүхээс ял шийтгүүлээд байна. Төрийн албаны холбогдох байгууллага ёс зүйн дүгнэлт гаргаж, албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас чөлөөлүүлэх хүртэл арга хэмжээ авахуулах санал, шаардлагыг тухайн томилсон эрх бүхий этгээд заавал хэрэгжүүлэх зохицуулалтыг хуульчлах хэрэгтэй байна. Энэ нь төрийн албанд ёс зүйг хэвшүүлэх, мөн удирдах албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

7. **Төрийн албан хаагчдын сургалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.** Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг мэргэшлийн ур чадварыг нь байнга дээшлүүлж байх ёстой. Ийм сургалтыг төрийн захиалгаар, төсвийн хөрөнгөөр тогтмол хийдэг систем тогтоох шаардлагатай байгаа болно. Сургалтыг төрийн албаны албан тушаалын ангилал, зэрэглэлээр ялгаварлаж, тусгайлсан боловсруулсан урт, богино, түргэвчилсэн, тусгайлсан програмаар явуулдаг болгох нь зүйтэй. Сургалтад төрийн албаны бүх шатны албан тушаалтан хамрагдах ёстой. Сургалтын нэг салшгүй хэсэг ёс зүйн сургалт байх ёстой.

8. **Төрийн албаны талаар гарсан гомдол, маргааны тухай шийдвэр заавал биелэгддэг байх ёстой.** Төрийн албатай холбогдож гарсан гомдол, маргааныг тусгай комисс хянан шалгаж, дүгнэлт гаргах, маргаан зөрчлийг арилгах, хуульд нийцүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан биелүүлэхгүй байх, өөрийн гаргасан илт буруу шийдвэрээ элдэв тайлбар гаргаж, хаацайлж хамгаалах, цаг хожиж өдөр өнгөрөөх оролдлого хийх зөрчил арилахгүй байна. Иймээс комиссын гаргасан дүгнэлт, шийдвэрийг заавал биелүүлдэг зарчимд шилжих шаардлагатай байна.

9. **Төрд болон төрийн албан хаагчдад учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлдэг болгох шаардлагатай.** Төрийн албан хаагч хуульд тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас улсад болон иргэдэд учруулсан хохирлын хэмжээ буурахгүй байна. Энэхүү хохирлыг төсвийн хөрөнгөөр барагдуулсаар өнөөдрийг хүрсэн билээ. Аливаа шийдвэрээ хуульд нийцүүлэн зөв гаргадаг болгохын тулд энэ зохицуулалтыг хуульчилж өгөх нь зүйтэй. Энэ нь нэгд, улсын төсөвт эрсдэл үүсгэхээс урьдчилан сэргийлэх, хоёрт, төрийн албан хаагчийн хариуцлагыг өндөржүүлэх чухал ач холбогдолтой.

10. **Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах хэрэгтэй байна.** Төрийн албан хаагчдын сарын дундаж цалин 805,3 мянган төгрөг байна. Төрийн жинхэнэ албан хаагч аливаа бизнес эрхлэхийг нь хуулиар хорьсон. Иймээс түүнийг нь нөхөх зорилгоор тухайн үедээ 36 хүртэл сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаа тусламж авах боломжийг хуулинд оруулж өгсөн. Гэхдээ тэтгэвэрт гарахдаа л авна. Гэтэл үүнийг дунджаар 12-18 сар болгож бууруулсан. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг өмнөх жишгээс дордуулсаар ирсэн болохоос биш системтэй тогтмол нэмэгдүүлж, хүрсэн түвшингээс нь бууруулахгүй бодлого барьж чадаагүй. Иймд төрийн албаны эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна.

### *Төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, боловсон хүчний нөхөн хангалтын зорилтын талаар.*

Төрийн алба тогтвортой байх нь төрийн албан хаагч мэргэшсэн байхтай салшгүй холбоотой. Төрийн албан хаагч мэргэшсэн байх гэдэгт түүнийг төрийн ажилд дадлагажуулах, ийнхүү туршлага суусны хэрээр түүнийг илүү хариуцлагатай ажилд шат ахиулан ажиллуулахыг ойлгоно. Үүнийг хангах үндсэн арга нь албан тушаал бүрийн зорилго, чиглэл, түүнд ажиллах хүнд тавигдах шалгуур маш тодорхой байх учиртай.

Гэтэл манайд үйлчилж байгаа хууль тогтоомж хэт ерөнхий. Иймд байгууллагууд албан тушаалд тавих мэдлэг чадварын шаардлагыг ерөнхий байдлаар, нийтлэг үзүүлэлтээр тогтоодог. Сул орон тоо гарсан тохиолдол бүрт ажил олгогч өөрийн сонирхож байгаа хүндээ тохируулан ажлын байранд тавигдах шаардлагыг өөрчлөх, яг ижил албан тушаалуудад өөр өөр шаардлага тавьж Төрийн албаны зөвлөлд ирүүлэх тохиолдол цөөнгүй байна.

Энэ бүхэн мэргэшээгүй, бэлтгэгдээгүй, тохиолдлын хүнийг улс төрийн хуваарилалт, захиалгаар төрийн албанд томилох бололцоог нээж байна. Түүнчлэн дадлага, туршлага суусан албан хаагчийг илүү хариуцлагатай ажилд шат ахиулан ажиллуулах шаардлага тэр бүр хэрэгжихгүй байна.

Зөвлөл, Ажлын алба хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллалаа. Төрийн байгууллагын батлагдсан орон тооны сул ажлын байр гармагц тухайн байгууллагаас ирүүлсэн захиалгын дагуу дараах арга хэмжээг зохион байгуулж ирлээ. Үүнд:

- Удирдах албан тушаалд нээлттэй уралдаант сонгон шалгаруулалтаар 52 иргэнийг, ажлын үр дүн, мэргэшлийн ур чадвараар дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх замаар 91 иргэнийг тус тус томилуулах саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.
- Удирдах болон гүйцэтгэх албан тушаалын нөөцийн бүртгэлд байгаа иргэдээс 454 иргэнийг нэр дэвшүүлж томилуулав.
- Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг 37 удаа зохион байгуулж 5236 иргэнийг хамруулж, хамгийн өндөр оноо авч шалгарсан 311 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилох санал, дүгнэлт гаргалаа.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд багагүй зөрчил бэрхшээлүүд гарсаар байна. Үүнд:

- Байгууллагууд сул орон тооны захиалгаа ирүүлэхгүй удаах, сул ажлын байрыг нийтэд мэдээлэхгүй байх, шаардлага хангахгүй болон сонгон шалгаруулалтгүй хүн авч ажиллуулах,
- Төрийн албаны зөвлөлөөс сонгон шалгаруулж, дүгнэлт гаргаж, санал болгосон иргэнийг томилохгүй, яагаад томилохгүй байгаа тайлбараа гаргахгүй байх,
- Шалгаруулалтад тэнцээгүй эсвэл тэнцсэн ч Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтгүй иргэнийг томилох зэрэг зөрчлүүд арилахгүй байна.

Дээрх сөрөг үзэгдлүүд байсаар байгаагийн нэг гол шалтгаан бол төрийн албаны томилгоонд улс төрийн оролцоо их байгаа явдал гэж олон нийт үзэж буй.

Төрийн албаны тухай хуульд 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулан төрийн албан хаагчдын намын харьяаллыг түдгэлзүүлсэн. Гэхдээ төрийн албанд улс төржих хандлага хэвээр байгааг баримтууд болон судалгааны дүнгүүд нотолж байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Мянганы хөгжлийн зорилт-9" төслөөс 2010 онд явуулсан судалгаанд оролцсон мэргэжилтнүүдийн 76.1 хувь нь "төрийн албан тушаалд улс төрийн нөлөө, танил талаар томилдог нь төрийн захиргааны албан тушаалд өндөр чадвартай хүмүүс ороход саад болдог" гэжээ.

Тэгвэл, саяхан явуулсан Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаарх санал асуулга, судалгаанд оролцогчдын 53.1 хувь нь "Төрийн алба улс төрөөс хамааралтай, түүнээс үүдэн төрийн албан хаагчдын чадавхи сул байна" гэсэн хариулт өгсөн байна.

Угтаа улс төрийнхөөс бусад төрийн албаны томилгоонд улс төрийн намын зүгээс огт оролцдоггүй, улс төрийн сонгууль ба түүний үр дүн төрийн албаны томилгоо болон хэвийн үйл ажиллагаанд нь огт нөлөөлөхгүй байх учиртай.

Иймд төрийн албыг мэргэшсэн, тогтвортой, үр нөлөөтэй байлгаж, түүнийг улс төржүүлэхгүй, авлигад өртүүлэхгүй, зохисгүй хүмүүст завшуулахгүй байх, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн байгууллага байх шаардлагатай гэсэн дүгнэлтийг судлаач, шинжээчид дэвшүүлж, олон нийт дэмжих байр суурьтай байна. Төрийн албаны "манаач" болох ийм байгууллагын эрх зүйн байдлыг Үндсэн хуульд заах нь дараах эерэг талтай гэж иргэд үзэж байна. Үүнд:

- Үндсэн хуулийн ийм байгууллага бий болсноор төрийн албаны бие даасан, хараат бус байдлыг хангахад үлэмж ач холбогдолтой.
- Үндсэн хуулийн хамгаалалттай болсноор улс төрийн зорилгоор төрийн албыг тогтворгүй болгох явдал эцэс болно.
- Төрийн албан хаагчдын баталгаа бодитоор хангагдана.
- Төрийн алба улс төрөөс ангид, хараат бус байснаар төрийн албан хаагчдын ур чадвар дээшилж, тэднээс гарч буй ажлын бүтээмж, гүйцэтгэл сайжирна.
- Төрийн албан хаагчдын сул чадавхиас болж хохирох иргэдийн тоо багасна.

Аль ч улсад төрийн албаны тогтвортой байдал нь түүнийг удирдаж байгаа байгууллагын бие даасан, хараат бус байдлаас ихээхэн хамаардаг болохыг гадаад орны туршлага ч нотолж байна. Монголын төрт ёсны түүхэнд ч ийм уламжлал, жишиг бас бий.

Уламжлал, шинэчлэлийг хослуулж, үндэсний онцлогийг дэлхий нийтийн хандлагатай зохистой хослуулах замаар төрийн албаны тогтвортой, үр нөлөөтэй механизмыг бий болгох, түүнийг хамгаалах Үндсэн хуулийн эрх мэдэл бүхий байгууллагын тогтолцоог бүрдүүлэх нь төрийн албаны эрх зүйн өнөөгийн шинэчлэлийн нэг тулгамдсан асуудал болоод байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН 2016 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН СТАТИСТИК МЭДЭЭ

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль 1995 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т "Төрийн албаны төв байгууллага нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа болон нөөцөд байгаа төрийн бүх албан хаагчийн тухай мэдээ агуулсан байна." гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөл 1995 оноос эхлэн төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, тэдгээрийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний жил бүрийн мэдээг дараа жилийн 1-р улиралд багтаан нэгтгэн гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-д хүргүүлдэг билээ.

Энэхүү тайланг 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар гаргав.

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний нэгдсэн тайланг Төрийн албаны зөвлөлд 2007 оноос хойш нэвтрүүлэн ашиглаж байгаа "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем"/HRMS-Human resource management system/-ынтусламжтайгаар гаргав. Энэхүү систем нь "Төрийн албаны тухай хууль"-д заасан төрийн албан хаагчдын ангилалд хамаарах бүх албан хаагчдын тухай мэдээллийг нийт 37 бүлэг үзүүлэлтээр нэгтгэдэг юм.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл болон төрийн байгууллагуудын хүний нөөцийн ажилтнууд дээрх үзүүлэлтээр хүний нөөцийн мэдээллээ тусгайлан боловсруулсан аргачлал, зааврын дагуу модуль болгон оруулсныг нэгтгэн боловсруулах замаар энэхүү тайлан мэдээг гаргасан болно. Тус тайланд төрийн албан хаагчдын байршил, харьяалал, албан тушаалын ангилал, зэрэг дэв, боловсрол, нас, хүйс болон төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөнд орсон шалтгаан зэрэг гол гол хэдэн үзүүлэлтээр товчлон гаргав.

# НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛЫН ТОГТОЛЦОО

## 1.1 МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛЫН ТОГТОЛЦООНЫ БҮДҮҮВЧ

*Зураг 1*






## 1.2 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО /байршлаар/

***Хүснэгт 1***

| ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД | |
|---|---|
| **Байршил /нутаг дэвсгэрээр/** | **Тоо** |
| Төрийн захиргааны төв байгууллагууд болон бусад* байгууллагууд | 493 |
| Нийслэл | 513 |
| Архангай аймаг | 148 |
| Баян-Өлгий аймаг | 166 |
| Баянхонгор аймаг | 174 |
| Булган аймаг | 146 |
| Говь-Алтай аймаг | 167 |
| Говьсүмбэр аймаг | 52 |
| Дархан-Уул аймаг | 95 |
| Дорноговь аймаг | 152 |
| Дорнод аймаг | 140 |
| Дундговь аймаг | 135 |
| Завхан аймаг | 209 |
| Орхон аймаг | 87 |
| Өвөрхангай аймаг | 192 |
| Өмнөговь аймаг | 142 |
| Сүхбаатар аймаг | 121 |
| Сэлэнгэ аймаг | 203 |
| Төв аймаг | 220 |
| Увс аймаг | 166 |
| Ховд аймаг | 162 |
| Хөвсгөл аймаг | 202 |
| Хэнтий аймаг | 186 |
| **Нийт** | **4271** |

* *Их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төвүүд, төрийн тусгай албаны болон соёл урлаг, музей, спортын байгууллагууд*

# ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, БҮРЭЛДЭХҮҮН

## 2.1 ТӨРИЙН НИЙТ АЛБАН ХААГЧДЫН ТОО

*/албан тушаалын ангилалаар/*

*Диаграмм 1*




## 2.2 ТӨРИЙН НИЙТ АЛБАН ХААГЧДЫН ТОО

*/байршлаар/*

*Диаграмм 2*




## 2.3 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН

*/байршлаар/*

*Диаграмм3*



## 2.4 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН

*/байршлаар/*

*Диаграмм 4*




## 2.5 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГУУДБОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙНАЛБАН ХААГЧДЫН ТОО

*/албан тушаалын ангилалаар/*

*График 1*




## 2.6 НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫНТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО

*/албан тушаалын ангилалаар/*

*График 2*



## 2.7 НИЙСЛЭЛИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО

*/албан тушаалын ангилалаар/*

*График 3*




## 2.8 ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО

*/албан тушаалын төрлөөр/*

*График 4*



## 2.9 ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НАСНЫ АНГИЛАЛ

*/хувиар/*

*График 5*




## ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НАСНЫ АНГИЛАЛ

***/тоогоор/***

***Хүснэгт 2***

| | | 20 хүртэлх нас | 21-25 нас | 26-30 нас | 31-35 нас | 36-40 нас | 41-45 нас | 46-50 нас | 51-55 нас | 56-60 нас | 60-с дээш нас | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **1320** | **14099** | **34819** | **32109** | **27466** | **26617** | **23461** | **19493** | **7927** | **1663** | **188974** |
| | | Залуу нас | | | | Дунд нас | | | Ахимаг нас | | Ахмад нас | |
| | | **82347** | | | | **77544** | | | **27420** | | **1663** | **188974** |
| № | Байршил | 20 хүртэлх нас | 21-25 нас | 26-30 нас | 31-35 нас | 36-40 нас | 41-45 нас | 46-50 нас | 51-55 нас | 56-60 нас | 60-с дээш нас | **Нийт дүн** |
| 1 | Архангай | 4 | 172 | 701 | 733 | 596 | 668 | 745 | 605 | 318 | 49 | **4591** |
| 2 | Баян-Өлгий | 7 | 130 | 810 | 1161 | 924 | 928 | 789 | 720 | 256 | 47 | **5772** |
| 3 | Баянхонгор | 7 | 251 | 911 | 804 | 644 | 677 | 708 | 527 | 192 | 24 | **4745** |
| 4 | Булган | 3 | 203 | 628 | 580 | 553 | 570 | 593 | 539 | 210 | 17 | **3896** |
| 5 | Говь-Алтай | 7 | 167 | 671 | 780 | 637 | 578 | 684 | 536 | 196 | 20 | **4276** |
| 6 | Говьсүмбэр | 2 | 90 | 254 | 211 | 181 | 196 | 135 | 124 | 40 | 9 | **1242** |
| 7 | Дархан-Уул | 3 | 184 | 582 | 662 | 729 | 801 | 673 | 662 | 232 | 34 | **4562** |
| 8 | Дорноговь | 8 | 273 | 808 | 761 | 568 | 553 | 484 | 374 | 159 | 23 | **4011** |
| 9 | Дорнод | 8 | 242 | 742 | 812 | 803 | 803 | 576 | 494 | 172 | 22 | **4674** |
| 10 | Дундговь | 5 | 216 | 611 | 533 | 418 | 410 | 450 | 389 | 151 | 27 | **3210** |
| 11 | Завхан | 4 | 230 | 755 | 917 | 750 | 783 | 868 | 668 | 246 | 26 | **5247** |
| 12 | Орхон | 4 | 209 | 563 | 636 | 621 | 768 | 714 | 610 | 160 | 15 | **4300** |
| 13 | Өвөрхангай | 5 | 326 | 960 | 910 | 657 | 707 | 762 | 667 | 188 | 15 | **5197** |
| 14 | Өмнөговь | 12 | 261 | 830 | 706 | 428 | 470 | 434 | 337 | 155 | 25 | **3658** |
| 15 | Сүхбаатар | 2 | 153 | 638 | 615 | 523 | 514 | 489 | 352 | 134 | 11 | **3431** |
| 16 | Сэлэнгэ | 2 | 311 | 1079 | 981 | 902 | 923 | 799 | 674 | 271 | 51 | **5993** |
| 17 | Төв | 3 | 303 | 893 | 847 | 768 | 825 | 804 | 712 | 325 | 46 | **5526** |
| 18 | Увс | 4 | 157 | 815 | 931 | 590 | 701 | 796 | 610 | 240 | 32 | **4876** |
| 19 | Ховд | 2 | 237 | 904 | 963 | 835 | 794 | 822 | 576 | 216 | 29 | **5378** |
| 20 | Хөвсгөл | 14 | 351 | 1168 | 1107 | 889 | 937 | 1043 | 800 | 289 | 32 | **6630** |
| 21 | Хэнтий | 5 | 244 | 758 | 815 | 748 | 659 | 646 | 515 | 217 | 17 | **4624** |
| 22 | Нийслэл | 411 | 3196 | 6379 | 5326 | 4665 | 4205 | 3216 | 2724 | 1212 | 372 | **31706** |
| 23 | Төрийн захиргааны төвбайгууллагууд болон бусад* байгууллагууд | 798 | 6193 | 12359 | 10318 | 9037 | 8147 | 6231 | 5278 | 2348 | 720 | **61429** |
| | **Нийт** | **1320** | **14099** | **34819** | **32109** | **27466** | **26617** | **23461** | **19493** | **7927** | **1663** | **188974** |
| | **Хувиар** | 0.70% | 7.46% | 18.43% | 16.99% | 14.53% | 14.09% | 12.41% | 10.32% | 4.19% | 0.88% | 100.00% |

* *Их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төвүүд, төрийн тусгай албаны болон соёл урлаг, музей, спортын байгууллагууд*

## 2.10 ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД

*/албан тушаалаар/* *Хүснэгт 3*

| Албан тушаалын ангилал | 2006 01.01 | 2007 01.01 | 2008 01.01 | 2009 01.01 | 2010 01.01 | 2011 01.01 | 2012 01.01 | 2013 01.01 | 2014 01.01 | 2015 01.01 | 2016 01.01 | 2017 01.01 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын Ерөнхийлөгч | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Монгол Улсын Их Хурлын дарга | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
